ҮГНЭЭС ҮЙЛ ХЭРЭГ РҮҮ

Нүүдэлчин малчид ба Монгол улсын томоохон уул уурхайн компанийн хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтийн байдал

accountability counsel

Аккаунтэбилити Коунсел

АГУУЛГА

Ерөнхий Хураангуй 1

Удиртгал 3

Замын зураглал ба Аргачлал 5

Илрүүлсэн зүйлс 7

Хүндрэлүүд ба Ололт амжилт 22

Малчдын Ойлголт 32

Дүгнэлт & Зөвлөмжүүд 36



Талархал

ГТЗ, ЭЗХНЗОГ-ын баг, ОТ Хяналт, бидэнтэй ярилцахын тулд цаг заваа гаргасан олон малчид болон энэхүү тайланг бэлтгэхэд ярилцлага өгсөн, мэдээлэл, тоо баримт цуглуулахад туслалцаа үзүүлсэн бүх хүмүүст чин сэтгэлийн талархал илэрхийлье.

ЕРӨНХИЙ ХУРААНГУЙ

Оюу Толгой уурхайгаас орон нутгийн ус, бэлчээрийн нөөц болон малчдын амьжиргаанд учруулж буй нөлөөллийн талаарх гомдлыг Ханбогд сумын малчид 2012 ба 2013 онд тус тус Олон Улсын Санхүүгийн Корпорацид (ОУСК) гаргасан. ОУСК-ийн хөндлөнгийн хариуцлагын механизм болох Эрх Зүйн Хяналт, Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений газраас (ЭЗХНЗОГ) Оюу Толгой ХХК ба орон нутгийн малчид хоорондоо эдгээр асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх хэлцлийг нь чиглүүлж ирсэн бөгөөд энэ явцад ус, бэлчээр, малчидтай холбоотой асуудлыг шийдвэрлэх эрх үүрэг бүхий, уурхай, малчид, орон нутгийн засаг захиргааны төлөөллийг оролцуулсан Гурван Талт Зөвлөл (ГТЗ) байгуулагдаж, олон жил хэлэлцээр хийсний эцэст 2017 оны 5 сард талууд малчдын гомдлыг барагдуулах Эцсийн хоёр Гэрээг байгуулсан билээ.

2017 онд тэдгээр гэрээнд гарын үсэг зурснаас хойш хэрэгжилтийг хангах талаар талууд мэдэгдэхүйц ахиц гаргажээ. Хэрэгжүүлэх ажил бодитой эхэлсэн, тэд нэг нэгнийхээ итгэлийг олсон, мөн Гэрээнүүдийг хэрэгжүүлэх эрмэлзэлтэй байгаа тухайд ГТЗ-ийн төлөөлөгчид санал нэгтэй байна. Өнөөг хүртэлх амжилтаас дурьдвал:

- Ханбогд суманд мал эмнэлгийн анхны лаборатори байгуулагдсан;
- Малчдын 37 хүүхдэд их дээд сургуулийн тэтгэлэг олгосон;
- 10 малчны худагт нарны эрчим хүчээр ажилладаг шахуурга суурилуулсан; мөн
- Уурхайн биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн 114 өрхөд нийт 945,000 ам.долларын нөхөн олговрын багц шинээр олгохоор баталсан.

Ийм ололт байхын зэрэгцээ явц санаснаас удаан, Гэрээгээр хүлээсэн үүргээс зөвхөн 58% нь төлөвлөлтийн анхан шатыг даван, бодитоор хэрэгжиж эхэлсэн бол 53% нь ГТЗ-ийн өөрийнх нь гаргасан хуваариас хоцорч байна. Ийнхүү хугацаа хоцорч буйн улмаас олон өрх айл Гэрээнүүдийн бодит үр өгөөжийг хүртээгүй байна. Зарим эмзэг өрхүүд ам бүлээ тэжээх, мал сүргээ эсэн мэнд байлгах гэж зүдэрсэн хэвээр байна. Амьжиргааг сайжруулж, хүнд бэрх байдлаас гаргах боломж бололцоо Гэрээнүүдэд байгаа, гол нь шуурхай, үр дүнтэй ахиц гаргах хэрэгтэй.

Нутгийн малчдад үнэхээр өгөөжөө өгөх хэрэгжилтийг амжилттай гүйцэтгэхийн тулд ГТЗ дараах зүйлсийг хийх ёстой. Үүнд:

- Ил тод байдлыг дээшлүүлж, орон нутгийн иргэдтэй харилцах явдлыг сайжруулах, хэрэгжилтийн явц болон дуусах хугацааны талаар тогтмол мэдээлэх гэх мэтчилэн. Үүнийг сайжруулахгүй бол мэдээлэл тараан түгээх явдал дутмагаас хардалт, төөрөгдөл бий болгон, хамгийн эмзэг хэсгийн малчид Гэрээний үр өгөөжийг хүртэж чадахгүй байдалд хүргэж мэднэ.
- Гэрээнд заасан ажлуудыг харилцан тохирсон зорилго, зориулалтын дагуу хэрэгжүүлэх явдлыг хангах, урьдчилан мэдэх боломжгүй хүндрэлээс болоод өөрчлөлт хийх шаардлагатай болсон ч ийм байдлыг хангах.
- Гуравдагч этгээд санхүүжүүлсэн эсвэл хэрэгжүүлж буй ажлуудыг нарийн хянан шалгаж, тухайн төслийн тавьсан зорилго, хугацаа, хамрах хүрээнээс хазайхаас сэргийлэх.
- ГТЗ-ийн төлөөлөгчдийн чадавхи, үүрэг хариуцлагыг байнга сайжруулах, ингэхдээ орон нутгийн засаг захиргаанд ГТЗ-ийн хийж буй ажлуудыг сайтар таниулж, мөн хувь нэмэр багатай төлөөлөгчдийг байнга сольж байх хэрэгтэй.
- Бие даасан, хүчтэй мониторинг, хяналтын механизм бий болгох. Гэрээний хэрэгжилтийн эхний үе шатуудад ЭЗХНЗОГ мониторингийн үүргийг гүйцэтгэж байлаа, харин цаашид ГТЗ өөрийн өмнө тавьсан зорилтуудаа хариуцлагатайгаар хэрэгжүүлэхэд мониторингийн өөр нэг байгууллага зайлшгүй байх шаардлагатай.

Малчдын өмчийн оёдлын хоршооллын гишүүн Мөнхсүрэн

УДИРТГАЛ

Оюу Толгой зэс, алтны уурхайгаас малчдын амьжиргаа, бүс нутгийн ус болон бэлчээрийн хомс нөөцөд учруулж буй нөлөөллийн талаарх гомдлыг барагдуулахын тулд малчид ОТ ба орон нутгийн засаг захиргаатай хэлэлцэн, 2017 оны 5 сард хоёр гэрээ байгуулсан. Эдгээр гэрээг хэрэгжүүлэх эхний 18 сарын явцыг энэхүү Тайланд үнэллээ.

2012 оны 10 сар ба 2013 оны 2 сард малчид албан ёсны гомдлоо Дэлхийн Банкны Группийн ОУСК болон Олон Талт Хөрөнгө Оруулалтын Баталгааны Агентлагийн (ОТХОБА) хариуцлагын газар болох ЭЗХНЗОГ-т гаргасан. ОУСК ба ОТХОБА нь ОУСК-ийн 400 сая ам.долларын зээл, ОТХОБА-ийн 1 тэрбум ам.долларын эрсдлийн баталгааг[1] оролцуулан уг төсөлд 2,2 тэрбум ам.долларын өр болон баталгааг гарган өгч, ОТ уурхайд дэмжлэг үзүүлсэн. Малчид гомдолдоо ОТ-н 2004, 2011 оны нөхөн олговрын хөтөлбөр учир дутагдалтай, хангалтгүй явагдсаныг дурдаж, уурхайн газар ба усны нөөцийг ашиглаж буй байдалд санаа зовж буйгаа илэрхийлэн, эрүүл мэндэд учрах нөлөөллийг бууруулж чадаагүй, малчдын уламжлалт нүүдлийн ахуй амьдралд учрах нөлөөллийг тооцоогүй, ялангуяа уурхайн талбайн дундуур өнгөрдөг, далд урсгалтай Ундай голын гольдролыг өөрчилсөн талаарх асуудлыг хөндсөн.

ЭЗХНОГ гомдлыг хүлээж аваад ОТ ба нутгийн малчид хоорондоо хэлэлцэж, шийдвэр гаргах хэлцлийн үйл явцыг нь чиглүүлсээр ирсэн. Энэ явцад ОТ, нутгийн малчид, Ханбогд сумын[2] засаг захиргаа оролцсон Гурван Талт Зөвлөлийг (ГТЗ) 2015 онд байгуулснаас хойш ОТ-н талаар малчдын гаргасан гомдлууд, түүнчлэн уурхайгаас мал маллагаа, бэлчээр, усанд учруулах нөлөөлөлтэй холбоотой ирээдүйд гарч болох аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх гол үүрэгтэйгээр ГТЗ байнга хуралдаж байна. Уурхайн нөлөөлөл, ОТ-н нөхөн олговрын өмнөх хөтөлбөрүүд хэр зохистой болсон зэрэгт судалгаа хийлгэн, гол асуултуудад хариулт авах зорилгоор талууд ГТЗ-өөр уламжлуулан хөндлөнгийн шинжээчдийн хоёр баг ажиллуулсан.

2017 оны 5 сард дөрвөн жил гаруй хэлэлцсэний эцэст талууд хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хоёр Эцсийн Гэрээ байгуулав. Уг гэрээнүүдэд ОТ-н нөхөн олговрын өмнөх хөтөлбөрүүдийн дутууг нөхөх; малчдын ус, бэлчээрийн нөөцийн хүртээмж зэргийг хамруулан малчдын амьжиргааг сайжруулах; малчдын мэдээлэл хүртэх, уурхайн ирээдүйн нөлөөллийн талаар санаа бодлоо илэрхийлэх чадварыг бэхжүүлэхэд чиглэсэн тус тусдаа 60 үүрэг амлалт тусгагджээ.

Эдгээр гэрээг байгуулсан нь өөрөө том амжилт мөн, гэхдээ нутгийн малчид ямар үнэлгээ өгөх нь тэдгээрийг хэр цаг хугацаандаа, ач холбогдолтой хэрэгжүүлэхээс шалтгаална. Гэрээнүүд бүрэн дүүрэн, үр дүнтэй хэрэгжвэл эх гомдлуудыг барагдуулна гэж талууд шийдвэрлэсэн. Энэхүү Тайланд тохирсон ажлуудын эхний 18 сарын хэрэгжилтийн явцыг үнэлж байгаа бөгөөд юу нь сайн болж байна, юу нь болохгүй байна, хэрэгжилтийг шуурхай, ач холбогдолтой хангахын тулд талууд саадыг хэрхэн даван туулах боломжийг судлах зорилготой. Түүнчлэн эдгээр ажлуудын үр өгөөжийг шууд хүртэх нутгийн малчид хэтийн төлөвийг хэрхэн харж буйг тусгахыг зорьсон болно.

1 ОУСК ба ОТХОБА нь 2.2 тэрбум гаруй ам.долларыг Монгол улсын ажлын байр, хөгжлийн хөдөлгүүр болох Оюу Толгойд олгоно. https://ifcextapps.ifc.org/ifcext%5CPressroom%5CIFCPressRoom.nsf%5C0%5CC64D74678BB89E2985257F1C0050C813.

2 Сум нь Монгол улсын засаг захиргааны хоёрдох жижиг нэгж, тойрогтой дүйцнэ. Сум дотроо багуудад хуваагддаг (хамгийн жижиг дэд-нэгж).

Онолбаатарын Хулан сургалтын тэтгэлэг авав

ЗАМЫН ЗУРАГЛАЛ БА АРГАЧЛАЛ

Энэ Тайланд 2017 оны 5 сард байгуулсан Эцсийн Гэрээнүүдэд заасан 60 үүрэг амлалтын биелэлтийг үнэлж байна.[3] Эх Гэрээнүүдэд зарим үүрэг амлалтыг хэд хэдэн газар давтсан тул энд үзэхэд хялбар болгон, явцыг илүү үнэн зөв тооцож гаргахын тулд давхардсан ажлыг хасан дахин дугаарлалаа.

Үүрэг амлалт тус бүрийн явцыг хяналтын үзүүлэлтийн жишиг багцаар тулган үзсэн болно. Үүнд:[4]

- Хэрэгжүүлэх нарийн төлөвлөгөө боловсруулсан эсэх
- Санхүүжилт батлагдсан эсэх
- Хэрэгжилтийн үйл явц эхэлсэн эсэх
- Хэрэгжилтийн үйл явц дууссан эсэх

Хэрэгжилтийн үйл явц эхлэх гэдэг нь төлөвлөлтийн шатнаас гарч, тодорхой алхмууд хийгдсэнийг хэлнэ. Мал нядлах шугам байгуулах гэх мэт биет барилга байгууламж барих төслийн тухайд барилгын ажил эхэлснээр хэрэгжилт эхэлсэн гэж үзнэ. Ахмад малчдын мэдлэг туршлагыг түгээх гэх мэт нийгмийн хөтөлбөрийн хувьд мэдлэг солилцох анхны ажиллагаа хийгдсэнийг хэлнэ.

Хэрэгжилт дууссан гэдэг нь ихэнх тохиолдолд ямар нэг ажил дутуу үлдээлгүйгээр үүрэг амлалт биелсэнийг хэлнэ. Хэрэгжиж буй ажлуудын тухайд тэдгээр нь хангалттай урт хугацаанд сайн, тогтмол хийгдэж байгаа бол дууссан гэж үзнэ. Жишээ нь байгаль орчны хамтын оролцоот мониторингийн хөтөлбөрийн хувьд эхний үйл ажиллагааны цикл ГТЗ хангалттай гэж үзсэнээр дуусч, хөтөлбөрийг үргэлжлүүлэхэд ямар нэгэн саад учрахааргүй болсныг хэлэх юм.

Хүснэгтэнд мөн үүрэг амлалтууд анх товолсон хугацаанаас хоцорч байгаа эсэхийг харуулсан байгаа. Тухайн ажил хугацаа хоцорч буй бол ГТЗ мэдээллийг шинэчилтэл эсвэл түүнийг хэрэгжүүлж дуустал хугацаа хоцорч байгаа гэж тооцогдох болно.

Доорх хэсэгт үүрэг амлалт тус бүрийн явцыг дээрх үзүүлэлтүүдээр тулган хянаж, өнөөг хүртэлх ололт ахицыг тайлбарлан харуулав. Дараагийн хэсэгт амжилтийн хүчин зүйлс болон тулгамдсан асуудлуудыг оруулсан ба түүнчлэн нийт малчид Гэрээний хэрэгжилтийн хэтийн төлөвийг хэрхэн үзэж байгааг нэгтгэн үзүүлэв. Сүүлийн хэсэгт тулгамдсан хүндрэлийг даван туулах болон цаашид хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой хэд хэдэн зөвлөмж өгөгдсөн болно.

Бүх үнэлгээг 2018 оны 6 -11 саруудад ГТЗ-ийн төлөөлөл, ЭЗХНЗОГ-ын зуучлагч, Гэрээний хэрэгжилтийн өгөөжийг хүртсэн буюу хүртэх нөлөөлөлд өртсөн малчид, гол үүрэг амлалтуудыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэн ажиллаж буй бие даасан ТББ зэрэг төрөл бүрийн хамааралтай талуудтай уулзаж, ярилцсаны үндсэн дээр хийв. Нийт 25 цагийн ярилцлага хийсэн. Түүнчлэн 2018 оны 6 сард ГТЗ, НОНХ-ны хуралд биечлэн ажиглагчаар оролцож, ГТЗ-ийн 2017 оны 5 сараас өнөөг хүртэлх хурлын тэмдэглэлүүд, хэрэгжилттэй холбоотой бусад бичиг баримттай танилцах замаар мэдээлэл цуглууллаа. Энэхүү Тайлангийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг хангахын тулд тайлангийн төслийг ГТЗ-ийн бүх талууд болон ЭЗХНЗОГ-д танилцуулан, санал хүсэлтийг нь авсан.

3 Бүх үүрэг амлалт Гомдол Барагдуулах Гэрээ1-ийн Хавсралт 1 болон (https://www.accountabilitycounsel.org/wp-content/uploads/2017/11/Complaint-Resolution-Agreement-1_ENG.pdf) Гомдол Барагдуулах Гэрээ 2-ын Хавсралт 1-д тус тус байгаа (https://www.accountabilitycounsel.org/wp-content/uploads/2017/11/Complaint-Resolution-Agreement-2_ENG.pdf).

4 Хүснэгтэд тэмдэглэсэнчлэн бүх жишиг үзүүлэлт үүрэг амлалт болгонд хамааралтай биш юм. Жишээ нь зарим ажлуудыг хийхэд ямар нэгэн санхүүжилт батлагдах шаардлагагүй бол үүнийг хувьчлан тооцохдоо харгалзан үзсэн.

Нөлөөлөлд өртсөн малчин Сүрэнхорол

ИЛРҮҮЛСЭН ЗҮЙЛС

Гэрээнд гарын үсэг зурснаас хойшх 18 сарын хугацаанд ГТЗ хэрэгжилтийн тухайд нэлээд мэдэгдэхүйц ахиц гаргасан байна. Энэ хэсэгт бидний зүгээс хэрэгжилтийн байдлыг судалсан үр дүнг тусгасан хүснэгтийг оруулж өгсөн бөгөөд гол гол амжилт болон нутгийн малчдад илүү өгөөжтэй үүрэг амлалтуудын тухайд өнөөг хүртэлх ахицыг дэлгэрэнгүй тайлбарлалаа. Ажил хэрэг болгох үйл явц жинхэнээсээ эхэлсэн, талууд нэг нэгнийхээ итгэлийг олсон, Гэрээнүүдийг хэрэгжүүлэх эрмэлзэлтэй байгааг ГТЗ-ийн гишүүд нийтээр хүлээн зөвшөөрч байна. Гэсэн хэдий ч зарим төлөөлөгчид одоохондоо ахиц “төдийлөн сайнгүй”, зөвхөн багахан үүрэг амлалт бүрэн хэрэгжиж, нутгийн малчдад өгөөжөө өгч эхэлж байгаа гэж байв. Энэ мэт сэтгэгдэл нь ахиц янз бүр, зарим чухал үүр амлалтыг хэрэгжүүлэхэд олон зүйл хийх шаардлагатай, бүх үүрэг амлалт амжилттай хэрэгжинэ хэмээн баталгаа өгөхөд эрт байна гэсэн бидний ерөнхий дүгнэлттэй тохирч байна. Доорх хүснэгтэд харуулсанчлан энэхүү хяналтаар дараах зүйлс илэрлээ. Үүнд:

61%

Төлөвлөлт шаардлагатай ажлуудын тухайд 61%-д дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулсан

29%

Үүрэг амлалтын 29% нь хэрэгжиж дууссан

60%

Санхүүжилт шаардлагатай ажлуудын 60%-ынх нь санхүүжилт батлагдсан

25%

Үүрэг амлалтын 25% нь хэрэгжилтийн ямар нэгэн шатанд хүрээгүй

58%

Үүрэг амлалтын 58% нь хэрэгжиж эхэлсэн

53%

Үүрэг амлалтын 53% нь ГТЗ-өөс тогтоосон хэрэгжилтийн хугацаанаас хоцорч байна

ҮҮРЭГ АМЛАЛТ	Анх тогтоосон цаг хугацаа**	Нарийн төлөвлө-гөө байгаа эсэх?	Санхүү-жилт батлагдсан эсэх?	Хэрэгжилт эхэлсэн эсэх?	Дууссан эсэх?	Өнөөг хүртэл авсан арга хэмжээ / тайлбар
ГЭРЭЭ 1						
Бэлчээр						
1. Алдагдсан бэлчээрийн бүст тохируулга хийхийн тулд бэлчээрийн тогтолцоог дахин боловсруулах	2017 улиралд төлөвлөгөө гарсан	Тийм	Байхгүй	Үгүй	Үгүй	Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулсан; иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдаагүй байгаа
2. Малчид худаг цоожлох, бэлчээрийн хүртээмжид хязгаар тавих явдлыг багасгах (гарын үсэг зурсан ашиглагчийн гэрээ)	2017 оны 3-р улирлын байдлаар 237 гэрээ байгуулсан	Тийм	Байхгүй	Үгүй	Үгүй	Гэрээг боловсруулж, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан
3. Худаг барих хөтөлбөрөөр дамжуулан шинэ бэлчээр нэмж бий болгох(#12); малчдын эзэмшлийн эрхийг тодорхой болгох	Бүх нөөц бэлчээрийг 2018 он гэхэд усжуулах	Үгүй	Байхгүй	Үгүй	Үгүй	Малчдын эзэмшлийн эрхийг тодорхой болгох талаар ахиц гараагүй; худаг барих явцыг #12-с үзнэ үү
4. Бэлчээрийн менежмент хийхэд нь орон нутгийн засаг захиргаанд дэмжлэг үзүүлэх (мэргэжлийн сургалтууд, шинжээчид томилон ажиллуулах)	2017 оны 3-р улирал гэхэд 5 мэргэжилтэн сургалтанд хамруулсан байх	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Сумын захиргааны 5 мэргэжилтэн бэлчээрийн зураглал гаргах сургалтанд хамрагдсан, дараагийн алхам тодорхойгүй
5. Мал маллагаатай холбоотой маргаантай асуудлыг шийдвэрлэхийн тулд ГТЗ малчид, одоо үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудыг дэмжих, уламжлалт арга барил ашиглах явдлыг идэвхтэй хөхүүлэх	2017 оны 3-р улирал	Үгүй	Байхгүй	Үгүй	Үгүй	Уст цэгүүдийн нээлттэй хүртээмж, өвлийн бэлчээрийг зуны улиралд ашиглахыг хориглох тухай Сумын засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангахад ГТЗ дэмжлэг үзүүлэх хэрэгтэй
6. Газар, усны нөөц ашиглах малчдын уламжлалт эрхийг баримтжуулан баталгаажуулах (бууцны кадастр)	2018	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй	Бүх өвөлжөө, зуны бууцны зураг хийгдэж байгаа
7. Малын тооны өсөлт, тавиул малын эзэн хэн болохыг тогтоох илүү дэлгэрэнгүй судалгаа шинжилгээ хийх	2017 оны 4-р улирал гэхэд малтай хүмүүсийн жагсаалт гаргах	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	Мал тооллого явагдаж байгаа; энэхүү дүн шинжилгээг хийх дэлгэрэнгүй төлөвлөгөө байхгүй

ҮҮРЭГ АМЛАЛТ	Анх тогтоосон цаг хугацаа**	Нарийн төлөвлө-гөө байгаа эсэх?	Санхүү-жилт батлагдсан эсэх?	Хэрэгжилт эхэлсэн эсэх?	Дууссан эсэх?	Өнөөг хүртэл авсан арга хэмжээ / тайлбар
8. ОТ-Ханбогдын зам дээрх мал амьтны гарамуудын ойролцоо хурд сааруулагч хийх асуудлыг хэлэлцэн, шийдвэр гаргах	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Хурд сааруулагч хийхгүй гэж шийдсэн.
9. ОТ-н урьд өмнө хийгдсэн ажлын улмаас эвдэрсэн бэлчээрийн газруудыг нөхөн сэргээх	2017–2027 онуудад үе шаттайгаар	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Зарим газруудыг эн тэргүүнд сэргээхээр заасан нөхөн сэргээх төлөвлөгөө хэрэгжиж байгаа; хэрэгжүүлж дуусахад олон жил орно.
10. Уурхайн хашаалсан талбайд түр хугацаагаар мал бэлчээрлүүлэх 2015 оны журмыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Хийгдэж байгаа	Тийм	Байхгүй	Тийм	Тийм	2018 онд хашаалсан талбайд мал бэлчээх санал ОТ –д ирээгүй
Ус						
11. ОТ-н усны татварын 50%-ийг сумын төсөвт эргүүлэн хуваарилах талаарх хүсэлтийг төв Засгийн газарт гаргах;	2017 оны 3-р улирал гэхэд хариу авах ⚠	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Ахиц байхгүй
12. Усны судалгаанд үндэслэн 4 багийн нутагт гар худаг шинээр гаргах (#17-г үзнэ үү)*	Худаг барих ажлыг 2018 онд эхлүүлэх ⚠	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Усны судалгааны үр дүнг хүлээж байгаа
13. Худаг барих, засах, арчлах засвар үйлчилгээний баг байгуулах (# 37-г үзнэ үү)	2017 оны 4-р улирал гэхэд худгуудыг засварласан байх ⚠	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй	200 сая төгрөг (78,100 ам.долл.) батлагдсан; хөтөлбөрийн загвар хувилбарыг гаргуулахаар хөндлөнгийн ТББ-ыг гэрээлсэн.
14. Шинэ худгийн хэрэгцээг шийдсэний дараа ОТ ус зөөж буйг аажмаар зогсоох	2018	Үгүй	Байхгүй	Үгүй	Үгүй	Шинэ худгууд баригдсаны дараа зогсоохоор төлөвлөж байгаа (#12)
15. Гүний хоолой орчмын гоожиж буй бүх цооногуудыг бөглөж; оргиж буй 2 цооногийг малчдад ашиглуулахаар тоноглох.	2016	Тийм	Тийм	Тийм	Тийм	2016 онд хийж дууссан
16. Малчдын хэрэглээнд зориулан тоноглосон 12 худгийг Ханбогд сумын захиргаанд хүлээлгэн өгөх	Q3 2017	Тийм	Тийм	Тийм	Тийм	Дууссан; хүлээн авах гэрчилгээ олгосон
17. Гидрологийн судалгаа (бэлчээрийн газрын усны нөөцийн судалгаа)*	2017 оны 2, 3-р улиралд ⚠	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	2018 оны 6 сард гүйцэтгэгчийг сонгох тендер явагдаж байв.

ҮҮРЭГ АМЛАЛТ	Анх тогтоосон цаг хугацаа**	Нарийн төлөвлө-гөө байгаа эсэх?	Санхүү-жилт батлагдсан эсэх?	Хэрэгжилт эхэлсэн эсэх?	Дууссан эсэх?	Өнөөг хүртэл авсан арга хэмжээ / тайлбар
Мониторинг, тайлагналт, орон нутгийн харилцаа						
18. Мониторингийг гадагш нь гэрээлж хийлгэж байгааг больж, орон нутгийн мониторингоор солих; малчдад зориулан мониторнигийн цалинтай ажлын байр бий болгох *	2018 оны 1-р сараас хэрэгжүүлж эхлэх	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй	240 сая төгрөгийг (93,590 ам.долл.) шинээр байгуулагдсан малчдын ТББ-д олгосон, мониторингийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулж байгаа
19. Хөөн хэлэлцэн олгож буй нөхөн олговрыг олгож буй байдлын талаар ОТ тайлагнаж байх	Улирал тутам	Тийм	Байхгүй	Тийм	Үгүй	ОТ улирал тутам ГТЗ-д тайлагнадаг; нөлөөлөлд өртсөн олон малчдад сүүлийн үеийн мэдээ хүрдэггүй
20. ОТ өөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл, ажил олголт, орон нутагт төлсөн татвар, хураамж, орон нутгийн худалдан авалт; байгаль орчны нөлөөлөл, байгаль орчны нөлөөллийн мониторинг ба менежмент, эмзэг бүлгийн хүмүүст тусалсан байдал, сургалт, бизнес хөгжүүлэлт, Хамтын ажиллагааны гэрээний төслүүд, хандив гэх мэт мэдээллийг жил бүр Ханбогд суманд гаргаж өгөх	Жил бүр	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Эдгээр тайланг гаргаж өгөх ажлын хэсэг байгуулагдсан. Эхний тайлан хараахан гараагүй байна.
21. ОТ-н орон нутгийн харилцааны ажлыг өргөжүүлэх (айл өрхөөр явах, багийн хурлуудад оролцох г.м.)	Айл өрхүүдээр жил бүр явах; улирал тутам тайлагнах	Тийм	Тийм	Тийм	Үгүй	ОТ багийн чадавх, орон нутагт чиглэсэн арга барилд ахиц гарч байгаа гэж мэдэгддэг; зарим малчид мэдээлэл тааруу, санал хүсэлтэнд хариу өгдөггүй хэвээрээ гэж байв.
22. ОТ-н гомдлыг барагдуулах механизмыг сайжруулах, гадны хөндлөнгийн этгээдэд хандах хувилбарыг тодорхой болгох.	2017 оны 2-р улиралд	Тийм	Тийм	Тийм	Үгүй	ОТ 2017оны 9 сард санал хүсэлт барагдуулах шинэчилсэн журам гаргасан; малчдыг өргөдөл гомдлоо ГТЗ-д өг гэдэг болсон гэж малчид хэлж байна

ҮҮРЭГ АМЛАЛТ	Анх тогтоосон цаг хугацаа**	Нарийн төлөвлө-гөө байгаа эсэх?	Санхүү-жилт батлагдсан эсэх?	Хэрэгжилт эхэлсэн эсэх?	Дууссан эсэх?	Өнөөг хүртэл авсан арга хэмжээ / тайлбар
Хувь хүний нөхөн олговор						
23. 2004 оны нүүлгэн шилжүүлэлт асуудалтай болсныг ОТ албан ёсоор хүлээн зөвшөөрөх	2017 оны 3 сарын 22	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Тийм	2017 оны 3 сарын ГТЗ-ийн хамтарсан мэдэгдэлд оруулсан.
24. Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хороо байгуулах (НОНХ)	2017 оны 3-р улирал	Тийм	Тийм	Тийм	Тийм	НОНХ-г 2017 оны 5 сард байгуулсан.
25. Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хорооны (НОНХ) үйл ажиллагааны журмыг батлах	2017 оны 2-р улирал	Тийм	Байхгүй	Тийм	Тийм	2017 оны 5 сард баталсан.
26. 2004 оны нүүлгэн шилжүүлэлт- шинээр шалгуур хангах нэхэмжлэлүүдийг хэлэлцэх & нөхөн олговор олгох	2017 оны 3-р улиралд эхлүүлэх	Тийм	Хэсэгчлэн	Тийм	Үгүй	Хоцрогдож байгаа; зарим нэхэмжлэлээр шийдвэр гараагүй; зарим нэхэмжлэлийн нөхөн олговрыг олгох хэрэгтэй хэвээр байгаа
27. 2004 онд нүүлгэн шилжүүлсэн өрхөөс ОТ-д ажлын байргүй өрхийг нэг жилийн хугацаатай тэтгэлэгтэй сургалтанд хамруулах	2017 оны 2-р улиралд эхлэх	Тийм	Тийм	Тийм	Тийм	ОТ-д ажлын байргүй 2 өрх 2017 оноос эхлэн нэг жилийн сургалтанд хамрагдсан
28. 2004 онд нүүлгэн шилжүүлсэн бүх өрхийг тогтвортой амьжиргааны хөтөлбөрт хамруулах (#36–42)	2017 оны 2-р улиралд эхлэх ⚠	Үгүй	Байхгүй	Тийм	Үгүй	Эдгээр үр өгөөжийг 2004 оны бүх өрхүүдэд хүртээхээр ажиллаж байна
29. 2011 оны эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт – шинээр шалгуур хангах нэхэмжлэлүүдийг хэлэлцэх & нөхөн олговор олгох	2017 оны 3-р улиралд эхлэх	Тийм	Хэсэгчлэн	Тийм	Үгүй	Хоцрогдолтой; зарим нэхэмжлэлээр шийдвэр гараагүй байгаа; зарим нэхэмжлэлийн нөхөн олговрыг олгох хэрэгтэй хэвээр байгаа
30. 2011 оны нөхөн олговрын гэрээний хэрэгжилт, үр дүнд хөндлөнгийн аудит, үнэлгээ хийлгэх;	Үр Дүнгийн Үнэлгээг 2017 онд дуусгах ⚠	Хэсэгчлэн	Хэсэгчлэн	Тийм	Үгүй	Үр Дүнгийн Үнэлгээг 2018 оны 7 сард хийж дуусгасан; ОТ гүйцэтгэлийн аудитыг тусад нь хийлгэх төлөвлөгөө байхгүй
31. Үр Дүнгийн Үнэлгээний дүгнэлтэнд үндэслэн 2011 онд нөхөн олговор авсан өрхүүдэд зориулан нэмэлт арга хэмжээ авах эсэхийг шийдэх	Үр Дүнгийн Үнэлгээг 2017 онд дуусгах ⚠	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Амьжиргаа нь сэргээгүй эсвэл тогтворгүй байгаа гэж үзсэн 16 өрхөд зориулан ОТ өрх тус бүрээр тусгайлсан хөгжлийн төлөвлөгөө боловсруулж байгаа

ҮҮРЭГ АМЛАЛТ	Анх тогтоосон цаг хугацаа**	Нарийн төлөвлө-гөө байгаа эсэх?	Санхүү-жилт батлагдсан эсэх?	Хэрэгжилт эхэлсэн эсэх?	Дууссан эсэх?	Өнөөг хүртэл авсан арга хэмжээ / тайлбар
32. Нөхөн олговор гүйцэд олгогдоогүй тухай нэхэмжлэлийг НОНХ-гоор хэлэлцэн, шийдвэрлэх	Үр Дүнгийн Үнэлгээг 2017 онд дуусгах	Тийм	Тийм	Тийм	Үгүй	НОНХ эдгээр нэхэмжлэлүүдийг хэлэлцсэн; болзол шаардлага хангасан өрхүүдэд бизнесийг дэмжих багц олгоно,
33. 2004 ба 2011 оны гэрээнүүд дэх нууцлалын заалтыг цуцлах	2017 оны 3 сарын 22	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Тийм	2017 оны 3 сараас эхлээд малчин өөрөө хүсэх юм бол өөрийн нөхөн олговрын гэрээний талаар бусдад ярьж, хэлэх эрхтэй болсон.
Нийтийн нөхөн олговор – шууд бус нөлөөлөлд өртсөн өрхүүдийг хамарсан "зорилтот бүлгийг" эн тэргүүнд тавих						
34. Ханбогд сумын Мал Аж Ахуйн Салбарын 2024 он хүртэлх Хөгжлийн Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2017–2024	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Анхдагч төслүүд хэрэгжиж байгаа эсвэл дууссан (мал эмнэлгийн лабораторийг 2018 оны хавар барьж дуусгасан).
35. Их сургуульд сурч буй малчны хүүхдэд сургалтын тэтгэлэг олгох *	2017 оны 6 сараас	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үргэлжилж байгаа – хичээлийн жил болгонд олгогдоно
Тогтвортой Амьжиргааны Хөтөлбөр ТАХ						
36. ТАХ Төсөл 1: Амьжиргааны ур чадвар олгох сургалт + Залуу малчныг дэмжих хөтөлбөр *	2017 оны 4-р улирлаас хэрэгжүүлж эхлэх	Үгүй	Хэсэгчлэн	Үгүй	Үгүй	Шаардлагатай санхүүжилтийн тал хувь нь батлагдсан
37. ТАХ Төсөл 2: Худаг, хашаа хороо засвар үйлчилгээний баг + хиймэл цөөрөм, ус хуримтлуулах цэгүүд *	2017 оны 4-р улирлаас хэрэгжүүлж эхлэх	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй	Эхний санхүүжилт батлагдсан; ТББ-ийн зөвлөх загвар хувилбарын талаар зөвлөгөө өгсөн; ГТЗ эцсийн шийдвэр гаргана
38. ТАХ Төсөл 3: Малчны зах, малын гаралтай түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээ бий болгох *	2017 оны 4-р улирлаас хэрэгжүүлж эхлэх	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн; ГТЗ бизнес төлөвлөгөө боловсруулж байгаа
39. ТАХ Төсөл 4: Малчдын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах *	2017 оны 3-р улирлаас хэрэгжүүлж эхлэх	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Эхний санхүүжилт 32 сая төгрөг (12,147 ам.долл.) батлагдсан; 2019 онд хэрэгжүүлнэ

ҮҮРЭГ АМЛАЛТ	Анх тогтоосон цаг хугацаа**	Нарийн төлөвлө-гөө байгаа эсэх?	Санхүү-жилт батлагдсан эсэх?	Хэрэгжилт эхэлсэн эсэх?	Дууссан эсэх?	Өнөөг хүртэл авсан арга хэмжээ / тайлбар
40. ТАХ Төсөл: Малын тэжээл тариалах хөтөлбөр *	2017 оны 4-р улирлаас хэрэгжүүлж эхлэх	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Техник эдийн засгийн үндэслэлээр бэрхшээлтэй асуудлыг гаргаж тавьсан; төслийг түр хугацаагаар зогсоосон, ГТЗ өөр хувилбар судалж байгаа
41. ТАХ Төсөл: Гүний худгуудыг сэргээгдэх (нарны) эрчим хүчтэй холбох *	2017 оны 4-р улирлаас хэрэгжүүлж эхлэх	Тийм	Тийм	Тийм	Үгүй	150 сая төгрөг (58,500 ам.долл) батлагдсан; эхний 10 худгийг 2018 оны 9 сард сэргээгдэх эрчим хүчинд холбосон
42. ТАХ Төсөл 7: Мал нядалгааны шугам барьж байгуулах *	2018 онд хэрэгжүүлж эхлэх	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Техник эдийн засгийн үндэслэл гарсан, ГТЗ бизнес төлөвлөгөө боловсруулж байгаа
43. ЖДҮ-ийн бизнест дэмжлэг үзүүлэх (сургалт, жижиг зээл)	2017 оны 4-р улирлаас хэрэгжүүлж эхлэх	Тийм	Тийм	Тийм	Тийм	ОУСК, Германы Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, Говийн Оюу Сан хамтран хэрэгжүүлэх өргөн хүрээ хамрах төсөлтэй нэгтгэсэн; эхний 3 жилд зориулагдсан 5.9 тэрбум төгрөгийн (2.3 сая ам.долл) санхүүжилт батлагдсан; төв нь Даланзадгадад баригдсан; Ханбогдын 4 хүн дэмжлэг авсан
44. Зам тавих, цэвэр ус, бохирын шугамд холбогдох талаар Ханбогд сумын Хөгжлийн Хороонд хандах	2017 оны 4 улирал	Үгүй	Хэсэгчлэн	Үгүй	Үгүй	Замыг хучилттай болгох санхүүжилт олгосон; ундны ус болон бохирын шугамын асуудлыг хэлэлцэх шаардлагатай
45. Юнителийн харилцаа холбооны антеныг Гавилууд багт суурилуулах	2017 оны 4 улирал	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Ахицгүй

ҮҮРЭГ АМЛАЛТ	Анх тогтоосон цаг хугацаа**	Нарийн төлөвлөгөө байгаа эсэх?	Санхүү-жилт батлагдсан эсэх?	Хэрэгжилт эхэлсэн эсэх?	Дууссан эсэх?	Өнөөг хүртэл авсан арга хэмжээ / тайлбар
ГЭРЭЭ 2: Ундай голын гольдролын өөрчлөлт						
Өмнөх хэсэгт буй (*) ийм тэмдэглэгээ бүхий үүрэг амлалтууд нь Гэрээ 1 ба Гэрээ 2 аль алинд нь тусгагдсан						
46. Ундайн голын гольдролыг өөрчилсөнтэй холбогдуулан албан ёсоор уучлал гуйсан захидлыг малчдад гардуулах	2015 оны 3 сарын 20	Тийм	Байхгүй	Тийм	Тийм	Уучлалт гуйсан захидлыг 2015 оны 5 сард нийтэлсэн
47. ОТ-н хаягдал чулуулгын овоолгын зураг төслийг өөрчлөн боловсруулж Бор Овоог хөндөхгүй хэвээр үлдээх	2016 оны 9 сарын 22	Тийм	Тийм	Тийм	Тийм	2016 оны 9 сард зураг төслийг өөрчилсөн
48. Бор Овоогийн шинэ задгайг ургамалжуулах	2016 оны 5 сар – 2018 оны 8 сар ⚠	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Бараг ахицгүй
49. Шинэ Задгайд Хуучин Бор Овоогийн Задгайн тухай мэдээлэл бүхий самбар байршуулах	2017 оны 3-р улирал	Тийм	Тийм	Тийм	Тийм	Хуучин Бор Овоон задгайн дурсгалд зориулан хөшөө босгосон, 2018 оны 12 сард ёслолын ажиллагаа хийхээр төлөвлөсөн.
50. Бор Овоогийн Задгайн фото зургийг Сумын Музейд байрлуулах	2015 оны 3 сарын 20	Тийм	Байхгүй	Тийм	Тийм	2015 оны 3 сард хийж гүйцэтгэсэн
51. “Говийн төгөл” төслийг хэрэгжүүлэх	2019 оны 10 сард дуусгах	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Хэсэгчлэн биелсэн, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гарсны дараа өөрчлөлт оруулж магадгүй
52. Уурхайн лицензит талбай доторх гурван хэсэг газарт Ундай голын урсгалыг чөлөөлж өгөх	Борооны улирлын үеэр	Тийм	Тийм	Тийм	Үгүй	2017 онд борооны улирлын үеэр арга хэмжээ авч дууссан ч үр дүнгүй болсон; ГТЗ өөр арга зам хайж байгаа
53. Халив-Дугатын өөрчлөлтийн сувгийн бүрэн бүтэн байдлыг сайжруулан, элэгдлийг багасгах	Борооны улирлын үеэр ⚠	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Ямар арга хэмжээ авах талаар ГТЗ шийдвэр гаргахаар ажиллаж байгаа.
54. Тогтоол ус хуралдах, Халив-Дугатын гол ууршихаас сэргийлэхийн тулд ус нэвтрүүлэн зайлуулах механизмтай болгох	Борооны улирлын үеэр ⚠	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Ямар арга хэмжээ авах талаар ГТЗ шийдвэр гаргахаар ажиллаж байгаа

ҮҮРЭГ АМЛАЛТ	Анх тогтоосон цаг хугацаа**	Нарийн төлөвлө-гөө байгаа эсэх?	Санхүү-жилт батлагдсан эсэх?	Хэрэгжилт эхэлсэн эсэх?	Дууссан эсэх?	Өнөөг хүртэл авсан арга хэмжээ / тайлбар
55. ОТ-н Техникийн Хяналтын Хөндлөнгийн Зөвлөл (ТХХЗ) Хаягдал Хадгалах Байгууламжийн шүүрэлт, зураг төсөлд оруулах өөрчлөлтийн талаар зөвлөмж гаргах	2017 оны 3-р улирал	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	ТХХЗ 2018 оны 8 сард ГТЗ-д 2 хуудас тойм тайлан өгсөн; тайланг бүтнээр авах тухайд талууд санал зөрөлдөж байгаа
56. Уст баг модны карьерын орчим хиймэл цөөрөм, хөв байгуулж ургамалжуулах	2018 оны 8 сар	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Цаашид нөхөн сэргээх ажил хийх шаардлагатай; урт хугацаанд хэрэгжинэ
57. Бэлчээрийн мониторингийн нэмэлт цэгүүдийг ОТ-н хамтын оролцоот мониторингийн хөтөлбөрт оруулах	2016 оны 8 сар	Тийм	Тийм	Тийм	Тийм	2016 оны 8 сард хийж гүйцэтгэсэн
58. Ундай голын ай савд нутагладаг малчин өрхүүдийн жагсаалт гаргах. Эдгээр малчид нь Гэрээ 2-ын үр өгөөжийг хүртэх "зорилтот бүлгийг" бүрдүүлнэ.	2017 оны 6 сар	Тийм	Байхгүй	Тийм	Тийм	Жагсаалт гарсан; шинэчлэх шаардлагатай болж магадгүй
59. Ахмад малчдын уламжлалт мал маллагааны мэдлэг, туршлагыг залуу малчдад өвлүүлэх төсөл хэрэгжүүлэх	2017 оны 4-р улирлаас хэрэгжүүлж эхлэх	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Эхний санхүүжилт 36 сая төгрөг батлагдсан (14,060 ам.долл); Сумын ахмадын холбоо 2018 оны 4-р улирлаас хэрэгжүүлж эхэлсэн
60. ОТ-н ажлын байран дах сургалтын боломжийг судлах	2017 оны 7 сард хэлэлцэх	Тийм	Тийм	Тийм	Тийм	ОТ мэргэжлийн сургалтын нэмэлт хөтөлбөрүүд гаргасан
НИЙТ:* **		35 / 57	27 / 45	33 / 57	17 / 59	

* Ийм тэмдэглэгээтэй нь Гэрээ 1 ба Гэрээ 2 аль алинд тусгагдсан үүрэг амлалт болно.

** Хугацаанаас хоцорч буй ажлуудыг улаанаар тэмдэглэв.

*** Нийт тоонд зөвхөн "тийм" гэсэн хариултыг тооцлоо.

Гэрээний хэрэгжилтийн талаарх сүүлийн үеийн мэдээллийг GTZyavts.com сайт руу орж үзнэ үү.

Нийтийн нөхөн олговор: сургалтын тэтгэлэг, мал эмнэлгийн лаборатори, сэргээгдэх эрчим хүчний шахуурга болон орон нутгийн хөгжлийн бусад төслүүд

Гэрээнүүдэд Ханбогд сумын нийт малчин өрхөд өгөөжтэй хэд хэдэн ажил тусагдсан. ОТ уурхай нийт иргэдэд нөлөөлөл учруулж байгааг хүлээн зөвшөөрч, эдгээр ажлуудыг нийтийн нөхөн олговрын хэлбэрээр гүйцэтгэхээр тохирсон. Нийтийн нөхөн олговрын ажлуудад малчдын хүүхдэд сургалтын тэтгэлэг олгох, худгыг сэргээгдэх эрчим хүчтэй холбох, малчдын зах, нядалгааны шугам байгуулах, хатуу өвөл, ган гачигийн үед хэрэглэх хамтын нөөц бүрэлдүүлэхийн тулд малын тэжээл тариалах гэх мэт болон мал маллагааг хөнгөвчлөх, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн бусад олон төрлийн орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүд орно.

Малчдын хүүхдэд сургалтын тэтгэлэг олгох хөтөлбөр бол хэрэгжилтийн эхний жилийн анхны амжилтын жишээ юм. Энэ амлалтын дагуу ОТ одоогийн байдлаар коллеж эсвэл их, дээд сургуульд сум орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц чиглэлээр, 2.7 доошгүй голч оноотой сурч байгаа малчны хүүхдэд сургалтын бүрэн тэтгэлэг олгохоор тохирсон. Гэрээнүүдэд гарын үсэг зурсаны дараа талууд шалгуур хангах оюутнуудын жагсаалтыг шуурхай гаргаж, сургалтын тэтгэлгийг батлуулснаар шалгуур хангасан малчдын 20 хүүхэд 2017–2018 оны хичээлийн жилд сургалтын төлбөрийн дэмжлэг авчээ. Тэдгээр хүүхдүүд суралцах хугацааныхаа туршид тэтгэлгийг жил бүр үргэлжлүүлэн авах юм.

2024 он хүртэл Ханбогд сумын Мал Аж Ахуйг Хөгжүүлэх Хөтөлбөр мөн ахицтай байна. Энэ хөтөлбөр 2017 оны гэрээнээс өмнө байсан хэдий ч сүүлд Гэрээнд хамруулснаар ГТЗ хяналт тавих болсон. Ингэснээр төслүүдээ ач холбогдлоор нь эрэмбэлэн, санхүүжүүлэлтийг хангахад тус болсон гэж бидний уулзаж ярилцсан ГТЗ-ийн гишүүд хэлж байв. Жишээ нь: Засаг захиргаанаас Ханбогд сумын төвд мал эмнэлгийн лаборатори барьж дуусгасан нь орон нутгийн урт хугацааны хөгжилд чиглэсэн төслүүдийн хүрээнд хийгдэх өргөн хүрээтэй төлөвлөгөөт ажлын нэг байсан. Уг төвийг 2017 ондоо барьж, ашиглалтанд оруулахаар төлөвлөснөөс бага зэрэг хоцрон 2018 оны эхээр дуусгажээ. Дараагийн хийвэл зохих зүйл нь лабораторийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах явдал юм. Энэ ажил ч хойшлогдож байгаа бөгөөд мэргэжилтнээр бүрэн хангах нь орон нутгийн засаг захиргааны төсвөөс шалтгаална. Лаборатори бүрэн ажиллагаатай болсноор орон нутгийн мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд арилжин борлуулахын тулд эрүүл мэнд, аюулгүй байдлыг шалган шинжлэхийн зэрэгцээ бусад олон төрлийн мал эмнэлгийн шинжилгээ, судалгаануудыг хийж гүйцэтгэх юм байна.

Нийтийн Нөхөн Олговорт Тогтвортой Амьжиргааны Хөтөлбөр, ГТЗ-өөр хэлэлцсэн орон нутгийн хөгжлийн хэд хэдэн төслүүд бас орно. Эдгээрийн нэг болох гүн өрмийн худгуудыг сэргээгдэх эрчим хүчтэй холбох ажил мэдэгдэхүйц ахицтай байна. Ингэснээр гүн өрмийн худгаас ус авахын тулд дизель хөдөлгүүр бүхий шахуурга суурилуулах, засаж арчлахтай холбоотой санхүүгийн болон нийгмийн дарамтаас малчдыг салгахыг зорьсон. Шахуургыг ажиллуулах дизель нь дийлэнх малчдын хувьд өртөг зардал ихтэй учраас бусад малчид түлш шатахууныг нь дуусгахаас сэргийлж зарим хүмүүс ийм шахуургатай худгаа цоожилдог хэмээн шүүмжлүүлдэг. Иймэрхүү үйлдэл усны хүртээмжийн асуудлыг улам хурцатгаж байв. Хэрэгжилтийн эхний жилд ГТЗ 150 сая төгрөгийн санхүүжилтийг (58,500 ам.долл) эхний ээлжинд 10 худгийг нарны эрчим хүчтэй холбохоор авчээ. Эдгээрийг саяхан суурилуулж дуусан бөгөөд малчдын сэтгэгдэл нэлээд нааштай байна. Харин энэ төслийн хүрээнд нэмж хэдэн худгийг сэргээгдэх эрчим хүчтэй холбох нь тодорхойгүй, Гэхдээ шаардлага хангасан худгийг нарны эрчим хүчинд холбуулах хүсэлт гаргасан аливаа малчинд хийж өгөх болно гэж ГТЗ-ийн төлөөлөгч хэлж байв. Цаашдын мониторинг, хяналтаар үүнийг баталгаажуулах хэрэгтэй.

Тогтвортой Амьжиргааны Хөтөлбөрийн бусад зургаан төсөл санаснаас нэлээд удаашралтай, нэг нь ч төлөвлөлтийн шатнаас хэрэгжилт рүү шилжээгүй байна. Үүнд малын тэжээл тариалах төсөл, мал нядалгааны шугам, малчны зах байгуулах, орон нутгийн малын гаралтай бүтээгдэхүүнийг боломжийн нийлүүлэлтийн сүлжээтэй холбох зэрэг нутгийн малчдын амьжиргааг дээшлүүлэх хамгийн их бололцоо бүхий Гэрээний томхон амлалт үүргүүд орж байна. Малчдад тусах ач холбогдлыг нь бодолцон ГТЗ эдгээр төслүүдийг харьцангуй богино хугацаанд гүйцэтгэхээр товлосон бөгөөд ихэнх нь хугацаа хоцрогдолтой байна.

Мал эмнэлгийн шинэ даборaторийн захирал Цэнд-Аюуш

Хоцрогдлын шалтгааныг ярилцах үеэр эдгээр том төслүүдийн учрыг олж, хэрэгжилттэй холбоотой тулгамдсан асуудлыг ойлгоход хугацаа шаардлагатай байснаас эхний 6 сард олигтой ахиц гараагүй гэж ГТЗ-ийн төлөөлөгчид хэлж байв. 2018 оны 6-р сард малын тэжээл туршилтаар тариалж эхэлнэ гэж төлөвлөсөн боловч 2018 оны 7 сард ГТЗ-д гаргаж өгсөн техник эдийн засгийн үндэслэлээр усжуулалтанд маш их ус шаардлагатай тул орон нутгийн нөхцөлд тэжээл тариалах бэрхшээлтэй болохыг тогтоосон. Тиймээс орон нутгийн нөхцөлд тохирсон өөр төсөл орлуулан хэрэгжүүлэх талаар ГТЗ саяхан шийдвэр гаргажээ. Малчны зах, нядалгааны шугамын төслүүд төлөвлөлтийн шатандаа байгаа бөгөөд тэдгээрийн өмчлөлийн бүтцийг ГТЗ дээр хэлэлцэж байгаа, мөн хэрэгжилтийн нарийн төлөвлөгөөг боловсруулж буй ажээ.

Нийтийн нөхөн олговрын эдгээр ажлуудыг урагшлуулваас малчдад ихээхэн өгөөжтэй байх болно. Ирэх саруудад эдгээр нь биелэлээ олно гэж малчид хүлээж, харж байгаа тул гаргаж буй хүчин чармайлтын эрчээ алдалгүй, шуурхай, үр дүнтэй, сайн мэдээлэлтэйгээр хэрэгжилтийг хангах явдал улам ач холбогдолтой болж байна.

Хувь хүний нөхөн олговор

Гэрээнд Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хороо (НОНХ) байгуулан, уурхайн улмаас биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн өрхүүдийг дэмжих зорилгоор 2004, 2011 онуудад хэрэгжүүлсэн нөхөн олговрын хөтөлбөрөөс зүй бусаар орхигдсон гэж үзэж буй малчдын өргөдөл хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэхээр заасан. ГТЗ төлөвлөсөн дагуу энэ байгууллагыг 2017 онд байгуулж, баримтлах шалгуур үзүүлэлт, ямар нөхөн олговор олгох зэргийг тодорхойлон, Үйл Ажиллагааны Журмыг нь боловсруулан баталжээ. Нөхөн олговрын анхны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үед алдаа доголдол гарсны улмаас зарим айл өрх нөхөн олговоргүй хоцорсон буюу эсвэл нөхөн олговрын багцыг хэд хэдэн өрхийн дунд хүчээр хуваж олгоход хүрсэн гэсэн хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтэнд үндэслэн НОНХ-г байгуулж, шалгуур үзүүлэлт гаргахаар тохирсон.

Малчдын төлөөлөгч Батцэнгэл нутгийн өрх айлынхантай ярилцаж байгаа нь

2017 оны сүүлээр НОНХ ОТ-н анхны нөхөн олговрын хөтөлбөрүүдээс зүй бусаар орхигдсон гэж үзэж буй өрхүүдийн өргөдлийг авч эхэлжээ. Өнөөг хүртэл 174 гаруй малчин өрх нэхэмжлэл гаргаснаас 114 нь шалгуур хангасан байна. Шинээр олгох нөхөн олговрын нийт дүн 945,000 ам.доллар. Хэдий ийм чухал ахиц дэвшил гарсан ч НОНХ шалгуур хангасан өрхүүдэд шинээр нөхөн олговор олгох эцсийн шатанд төлөвлөсөн хугацаанаас дэндүү хоцорсон нь харамсалтай. ОТ өчнөөн сар хүлээлгэж байж 2018 оны 8 сард түрүүчийн хоёр өрхөд нөхөн олговрын эхний багцыг олгожээ. Түүнээс хойш шинээр шалгуур хангасан өрхүүдийн 58 нь нөхөн олговроо авсан гэж ГТЗ мэдээлсэн. Саяхан ГТЗ-өөс нөхөн олговортой холбоотой нэхэмжлэл нэмж хүлээн авах хугацааг 2019 оны 1 сарын 5-наар тасалбар болгоно хэмээн зарласан байна.

2011 онд нөхөн олговрын багц авсан малчин өрхүүдийн хувьд 2011 оны нөхөн олговрын хөтөлбөрт үр дүнгийн үнэлгээ хийж, өрхийн амьжиргааг тухайн үеийн түвшинд хүртэл сэргээхийн тулд нэмж авах арга хэмжээг боловсруулан, хэрэгжүүлэхийг Гэрээнд үүрэг болгосон. Үр Дүнгийн Үнэлгээний эцсийн тайлан 2018 оны 7 сард гарч, 92 өрхөөс 16-д нь нэмэлт туслалцаа шаардлагатай гэж дүгнэжээ: долоон өрхийн амьжиргаа 2011 оноос хойш уруудсан, дөрвөн өрх ядуурлын түвшнээс доогуур амьдралтай, таван айл ОТ-н зөөврийн уснаас хамааралтай тул тогтвортой амьжиргаатай болж чадаагүй байна. ГТЗ эдгээр 16 өрх тус бүрт тусгайлан зориулсан амьжиргаа дэмжих төлөвлөгөө гаргах шаардлагатай гэж тохирчээ. Ийм үр дүн үлдсэн бусад 76 өрхийн урмыг хугалж магадгүй, 6 сард биднийг явж байх үед 2011 онд нөхөн олговор авсан өрхүүдэд нэмэлт тусламж шаардлагатай байгаа талаар хүмүүс дахин дахин дурдаж байсан. Амьжиргаа бүрэн сэргэсэн ангилалд зүй бусаар оруулсан гэж үзэж буй аливаа өрх нэг бүртэй ГТЗ уулзаж, юуны өмнө судалгааны үр дүнг тодорхой танилцуулан, тайлбарлаж, Гэрээний үүрэг амлалтын хүрээнд хүртэж болох бусад үр өгөөжийг хэлж ойлгуулах шаардлагатай.

Хувь хүний нөхөн олговрын багц бол Гэрээгээр дамжуулан хүртэж болох хамгийн түргэн бөгөөд барьцтай үр өгөөж байж магад, нөгөө талаар энэ нь амьжиргаагаа залгуулах гэж ядаж буй өрхүүд болон шударга бусаар хасагдсан гэж үзэж буй хүмүүсийн тухайд сэтгэлийг нь эмзэглүүлж мэдэх сэдэв юм. Хувь хүний нөхөн олговрын талаарх үүрэг амлалтуудыг хангалттай хэрэгжүүлж дуусгахын тулд асуудлын ач холбогдлыг ойлгон, нэлээд бодолтой, хүнлэг энэрэнгүй аргаар хандах нь зүйтэй.

Нөлөөлөлд өртсөн малчин Доржханд тэрийнхээ хажууд

ОТ-н байгаль орчны нөлөөлөлтэй холбоотой үүрэг амлалтууд: бэлчээр, ус, мониторинг, Ундай гол

Бэлчээр, ус, мониторингийг сайжруулах болон Ундай голын нөлөөлөлтэй холбоотой Гэрээний амлалт үүргүүд нь бүгд ОТ уурхайгаас байгаль орчинд учруулж буй нөлөөллүүдэд төвлөрсөн. Амлалт үүргийн зарим нь эдгээр байгаль орчны нөлөөллүүдийн талаарх малчдын ойлголтыг сайжруулах, тэдгээрийг сайтар бууруулахад чиглэж байна. Бусад нь нийт сумын хэмжээнд бэлчээр, усны хүртээмжийг сайжруулах арга хэмжээнүүдийг хамарна. Орон нутгийн бэлчээр, усны хомсдолд ОТ нэмэрлэж байгаа тухайд ГТЗ дэх талууд санал нэгтэй биш хэдий ч орон нутгийн малчид уламжлалт амьжиргаагаа цаашид авч явах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд эдгээр бэрхшээл саадыг зайлшгүй шийдвэрлэх хэрэгтэй гэдгийг бүх талууд хүлээн зөвшөөрч байна.

Бэлчээртэй холбоотой үүрэг амлалтууд

Бэлчээртэй холбоотой үүрэг амлалтуудын тухайд орон нутгийн засаг захиргааны ажилтнуудыг бэлчээрийн менежментийн сургалтанд хамруулахад гол ахиц гарчээ. Өнөөгийн байдлаар сумын засаг захиргааны 5 ажилтан бэлчээрийн зураглалын сургалтанд хамрагдсан байна. Бэлчээрийн нөлөөллийг шийдвэрлэхтэй холбоотой олон ажил хойшлогдсон, эсвэл хугацаа хоцорч байна. Сумын мал эмнэлэг, үржүүлгийн тасгийн дарга нас барсан болон сумын засаг захиргааны зарим ажилтнууд өөрчлөгдсөний улмаас хойшлогдож байгаа гэж ГТЗ-ийн төлөөлөгчид хэлж байлаа. Ямар ч байсан ирэх жилүүдэд бэлчээртэй холбоотой үүрэг амлалтыг хэрэгжүүлэхэд илүү ахиц гаргах шаардлагатай.

Устай холбоотой үүрэг амлалтууд

Гэрээнд заасан усны нөөцийг шийдвэрлэхтэй холбоотой амлалт үүргийн дотор Ханбогд суманд ашиглагдаагүй байгаа усны нөөцийг тогтоох, усны хангалттай нөөц тогтоогдсон газарт малчдад шинээр худаг гаргаж өгөх ажлууд орсон. Бид ярилцлага хийж байх тэр үед Ханбогд сум гантай, усны нөөц тун хомсдсон байсан болоод ч тэр үү малчидтай уулзахад эдгээр үүрэг амлалтын талаар байнга ярьж байлаа. 2018 онд худаг барих ажлыг эхлүүлнэ гэж Гэрээнд хугацаа заасан. 2018 оны 6 сард усны судалгаа хийх болон худаг барих санхүүжилтийн санал Говийн Оюу Сангаар[5] батлагдаад, судалгаа хийх гэрээт гүйцэтгэгчийг шалгаруулах тендер явагдаж байв. Үүрэг амлалтуудад барих худгийн тоог заагаагүй ч өгсөн саналыг үзвэл Ханбогд сумын хэмжээнд ердөө 12 худаг барихаар тусгажээ. Дараа сонсоход худаг барих ажил 2019 оноос нааш эхлэхээргүй байна гэж байв. Гэхдээ ажил гүйцэтгэх санал нь Гэрээний үүрэг амлалтын зорилго, зориулалттай тохирох эсэх, түүний хэрэгжилтэнд ГТЗ хангалттай үүрэгтэй байж чадах эсэх нь тодорхойгүй байгаа талаар дараагийн хэсгүүдэд дурьдсан болно.

Мониторингтой холбоотой үүрэг амлалтууд

Хамтын оролцоот мониторингийн хөтөлбөр бага багаар урагшилж байна. Нутгийн малчид мониторингийн ажлыг хийж гүйцэтгэх “Мөнх Ногоон Галба” гэдэг малчдын Төрийн Бус Байгууллага (ТББ) байгуулсан. 2018 оны 6 сард уг ТББ 240 сая төгрөгийн (93,590 ам.долл.) эхний санхүүжилтийг Говийн Оюу Сангаас хүлээн авч, 2018 оны 7 сард үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулжээ. Энэ ТББ нь ус, агаарын чанар, ургамалжилт, зэрлэг амьтдыг ажиглах зэрэг байгаль орчны мониторингийн хэд хэдэн ажлыг гүйцэтгэж, малчдад мониторинг хийсний хөлс олгох юм. Өнөөгийн байдлаар ахиц сайн ч төлөвлөж байснаас 6 сар гаруй хойшилсон, түүнчлэн мониторингийн ажлын хэмжээ нь анх төлөвлөж байснаас хумигдсан байна (энэ талаар дараа яригдана).

Ундай голтой холбоотой үүрэг амлалтууд

Ундай голын нөлөөлөлтэй холбоотой үүрэг амлалтын хэрэгжилт мөн зогсонги байдалтай байна. Техникийн Хяналтын Хөндлөнгийн Зөвлөлөөр (ТХХЗ) Хаягдал Хадгалах Байгууламжийн (ХХБ) шүүрэлтийг хянуулж, ХХБ-ийн зураг төсөлд оруулах өөрчлөлтийг санал болгож, урсгалын доод руу гарч болзошгүй нөлөөллийг судлан, үр дүнг ГТЗ-д тайлагнах үүргийг ОТ хүлээсэн. Мөн санал болгосон өөрчлөлтүүдийг ОТ хийж гүйцэтгэх үүрэгтэй. Өнөөгийн байдлаар ОТ PowerPoint товч танилцуулга хийн, ТХХЗ 2017 оны 10 сард сайтад ажилласан тайлангаас 2 хуудас хураангуй “тайлан” өгөөд байна. Эдгээрт хаягдлын далангийн шүүрэл, тэдгээрээс урсгалын доод руу ямар нөлөөлөл учруулах тухайд хийсэн дэлгэрэнгүй дүгнэлтийг тусгаагүй. 2017 оны 3 сард хийсэн судалгааны үр дүнд үндэслэн ОТ хийхээр төлөвлөж буй өөрчлөлтүүдийн талаар PowerPoint танилцуулгад байгаа ч тухайн өөрчлөлтийг хийхэд

5 Говийн Оюу Сан, албан ёсоор Хөгжлийг Дэмжих Сан гэдэг, ОТ ба Монгол улсын засгийн газар хоорондын 2015 оны Хамтын Ажиллагааны Гэрээний хүрээнд байгуулагдсан. Өмнөговь аймгийн хөгжлийн төслүүдийг дэмжихийн тулд ОТ жил бүр 5 сая ам.доллар Санд оруулах үүрэгтэй.

2018 оны 8 сард орсон ширүүн борооноор гэнэтийн үер буужээ

хүргэсэн судалгааны дүгнэлтийн талаарх мэдээлэл алга. ГТЗ-ийн төлөөлөгчидтэй хийсэн ярилцлагаас Гэрээний энэ амлалт үүргийг биелүүлэхэд шаардагдах мэдээллийн нарийвчлалын түвшний тухайд талууд санал нийлэхгүй байгаа юм байна гэж ойлгогдлоо. Одоо болтол Гэрээний энэ амлалт үүргийг хэрэгжүүлэхэд хангалттай мэдээллийг ОТ нэмж өгөөгүй байна.

Халив-Дугатын голын бүрэн бүтэн байдлыг сайжруулах болон Ундай голын урсацыг чөлөөлөх ажлын ахиц бүр ч дулимаг байна. Эдгээр үүрэг амлалтууд нь эвдрэлийг багасган, үерийн усыг үр ашигтай урсгах, уурхайтай холбоотой саад бэрхшээл байгааг үл харгалзан голын урсацыг байгалиар нь урсгах явдлыг хангах зорилготой билээ. Өнөөдрийн байдлаар талууд Халив-Дугатын голын урсацыг сайжруулахад чиглэсэн тодорхой арга хэмжээг хэлэлцэж тохироогүй л байна. 2017 онд Ундай голын урсацыг сайжруулахаар авсан арга хэмжээнүүд нь үр дүн авчраагүй. 2018 оны 8 сард хүчтэй бороо орсны дараа хоёр гол аль аль нь нэлээд үерлэж, Уурхайн лицензит талбайн дотор хаягдлын далангийн ойролцоо ихээхэн хэмжээний үерийн ус тогтсон байсан. Өмнөх үеүүдээр яг ингэж тогтоол ус үүсч, тэдгээр нь гадаргын урсац, гүехэн гүний ус, ууршилт зэрэгт сөргөөр нөлөөлж болзошгүй байсан учраас Гэрээнд эдгээр амлалт үүргүүдийг оруулсан билээ. 2018 оны 8 сард болсон үер хоёр голын бүрэн бүтэн байдлыг сайжруулах шийдэл олох шаардлага байсаар байгааг харууллаа.

Малчдын хувьд өнөөгийн тулгамдсан хэрэгцээ, Ханбогд сумын уламжлалт мал аж ахуйн ирээдүйн асуудлыг байгаль орчинд цаашид учрах эрсдэл гэх мэт бусад асуудлаас эн тэргүүнд тавьж буйг ойлгож байна. Тийм болохоор байгаль орчны алсыг харсан асуудалтай холбоотой үүрэг амлалтын хэрэгжилтийг урагшлуулах тухайд тэдний зүгээс ГТЗ-ийг шахаж шаардах нь бага байгаа гэсэн үг. Гэсэн хэдий ч өнгөрсөн, одоо, ирээдүйн байгаль орчны нөлөөлөлтэй холбоотой Гэрээний үүргийг бүрэн гүйцэд, няхуур хэрэгжүүлэх нь чухал бөгөөд цаашид ОТ уурхай, нутгийн малчдын хооронд зөрчил үүсэхээс сэргийлж, алсдаа ГТЗ-ийн цаг, хүч нөөцийг хэмнэхэд тустай билээ. ОТ уурхай үйл ажиллагаагаа өргөжүүлэн, урт удаан хугацаанд оршин ажиллах учраас нутгийн малчид байгаль орчны асуудлыг эн тэргүүнд тавьдаг болох буй за. Тэр үед байгаль орчны нөлөөллийг бууруулах арга хэмжээ бэлэн, талууд бүгд ойлголттой, итгэл хүлээсэн хамтын оролцоот мониторингоор хянадаг байх нь аль аль талдаа тустай байх болно.

Малчдын төлөөлөгч Намсрай ОТ-н байгуулсан хиймэл задгайн дэргэд байгаа нь

ХҮНДРЭЛҮҮД БА ОЛОЛТ АМЖИЛТ

Бид энэ судалгаагаар талуудад учирсан, цаашдын хэрэгжилтийн шатанд ч гарч болох нэлээд хэдэн хүндрэлүүд, мөн түүнчлэн эхний жилд олсон ахицанд нөлөөлсөн хэд хэдэн амжилттай стратегийг тодорхойллоо. Энэ хэсэгт талуудад учирч буй бодит болон болзошгүй саад тотгорууд, мөн хэрэгжилтийг амжилтанд хүргэх стратегиудыг дурдан орууллаа.

Оновчгүй тогтоосон цаг хугацаа, тодорхой бус явцын тайлан зэрэг нь олон нийтийн урмыг хугалж, үл ойлголцол үүсгэх эрсдэлтэй

60 үүрэг амлалтаас 31 нь ГТЗ-ийн өөрийнх тогтоож, Гэрээнд тусгасан хугацаанаас хоцорсон, дийлэнх нь хэд хэдэн сараар хойшлогдсон байна. Хувь хүний нөхөн олговрын нэхэмжлэлийг авч үзсэн байдал үүний тод жишээ юм. Шалгуур хангаж буй нь тогтоогдсон зарим өрх хувь хүний нөхөн олговрын шинэ багцыг авах гэж 9 сар гаруй хүлээжээ, гэтэл НОНХ-ны Үйл Ажиллагааны Журамд шалгуурыг хангаж буй нь тогтоогдсоноос хойш 45 хоногийн дотор нөхөн олговрыг олгоно гэж заасан. Үүнтэй нэгэн адил Тогтвортой Амьжиргааны Хөтөлбөрийн бараг бүх төсөл анх тогтоосон хугацаанаас маш их хойшилсныг дээр дурдсан. Малын тэжээл тариалах хөтөлбөр, малчны зах, нядалгааны шугамын ажлууд удаашралтай, эдгээрийн аль ч төсөлд дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулаагүй байгаа аж. Нэмж хэлэхэд, саяхан малын тэжээл тариалах төслийг больж, яг юу хийх тухайд тодорхой шийд гараагүй өөр төслөөр орлуулахаар тохирсон нь шаардагдах усны хэрэгцээ талаасаа зүй зохистой шийдвэр болсон, гэхдээ хугацааг бүр л хойш нь татах болно.

ГТЗ-ийн төлөөлөгчидтэй ярилцаж байхад ихэнх нь цаг хугацааг эхлээд товлохдоо дэндүү дэвүүн хандсанаа хүлээн зөвшөөрсөн бөгөөд зарим нэг амлалт үүргийн тухайд энэ нь үнэний ортой байж магадгүй. Гэвч хугацаа хоцорсон бүх ажлын хойшлогдсон шалтгаан энэ гэхэд итгэхэд бэрх. Жишээ нь ОТ-н усны төлбөрийн зарим хэсгийг Сумын төсөвт оруулах тал дээр юу ч хийгдээгүй байна; ядахдаа үүнийг хэрэгжүүлэх нарийн төлөвлөгөө гаргахад 18 сар хангалтгүй байсан гэхэд үнэмшмээргүй. Үүний нэгэн адил харилцаа холбооны антен суурилуулах гэх мэт зарим жижиг ажлууд 18 сарын туршид багахан ахисан эсвэл огт урагшлаагүй байна.

Ямар ч шалтгаантай бай дэндүү оновчгүй цаг хугацаа тавьсан нь бодит бус хүлээлт үүсгэн, үр өгөөжийг нь хүртэнэ хэмээн горилж суугаа малчдын дургүйцлийг төрүүлж, итгэл алдрахад хүргэж болзошгүй. Харамсалтай нь энэ байдал үргэлжлэх төлөвтэй: ГТЗ өнгөрсөн 18 сарын хугацаанд том төслүүдийг хэрэгжүүлэхэд ихээхэн цаг хугацаа, хүчин чармайлт шаардлагатай болохыг ухаарсан хэдий ч Гэрээнд заасан хугацаанд өөрчлөлт оруулаагүй. Тиймээс нутгийн малчид хэрэгжилтийн цаг хугацааны талаар үнэн зөв, сүүлийн үеийн мэдээлэл авч чадахгүй байна.

Хэрэгжилтийн цаг хугацааны талаар бодитой, сүүлийн үеийн мэдээ хүргэхийн оронд 2018 оны 6 сарын ГТЗ-ийн хурлаас гаргасан хамтарсан мэдэгдэлд ямар ажлууд үлдээд байгааг дурдсан нь дахиад нутгийн малчдын дунд бодит бус хүлээлт үүсгэх эрсдэлийг дагуулж байна. Хамтарсан мэдэгдэлд хоёр гэрээний үүрэг амлалтын 70–79% нь хэрэгжиж дуусан эсвэл ойрын болон урт хугацаанд хэрэгжүүлж дуусгана[6] гэжээ. ГТЗ хэрэгжилтийн явцыг бүртгэхдээ “төлөвлөлт” хийгдээд, хэрэгжүүлэхэд чиглэсэн ямар нэгэн тодорхой ажиллагаа хийж эхэлмэгц “богино хугацаанд дуусгах”, “урт хугацаанд дуусгах” гэж хоёр ангилдаг аж. Энэ нь тэдгээр хоёр ангилалд дөнгөж эхэлж байгаа, мөн бараг дуусч буй ажлууд аль алиныг хамруулж байна гэсэн үг. Ингэснээр ГТЗ бодит байдал дээр ахиц ямар байгааг бүрхэгдүүлэн, өнөөг хүртэл нутгийн малчдад хүрсэн үр өгөөж бага байхад үүрэг амлалтын 70% биелсэн эсвэл бараг биелж байгаа гэж үзэж байгаа мэт ойлголт төрүүлж байна.

Түүнээс гадна, тэдний 70–79% гэсэн тооцоонд хэрэгжиж эхэлсэн бүх ажлыг хамарсан гэж үзээд ч энэ нь бидний гүйцэтгэлийг үнэлэх судалгаагаар үүрэг амлалтын зөвхөн 58% хэрэгжиж эхэлж байгаа гэж гарснаас илт илүү байгаа юм. Ийм зөрүүтэй байгаа нь Гэрээнүүдэд хэд хэдэн газар давтагдсан зарим үүрэг амлалтыг ГТЗ давхардуулан тооцож байгаатай холбоотой байж магадгүй. ГТЗ мөн үүрэг амлалтын явцыг ангилахдаа биднээс илүү аядуу ханддаг бололтой. Өөрөөр хэлбэл ГТЗ тодорхой үүрэг амлалтуудын явцыг дүгнэхдээ өөрсдийн байдлыг хэтрүүлж үнэлсний улмаас ГТЗ-ийн явцын тайлан болон нутгийн малчдад хүрч буй бодит үр дүн хоорондоо ялгаатай байгаад байна.

Нэмж хэлэхэд ГТЗ-ийн “бүрэн хэрэгжсэн” гэх ангилалд өнгөрсөн 18 сард гүйцэтгэсэн ажлууд, түүнчлэн 2017 оны 5 сард Эцсийн Гэрээ байгуулахаас өмнө тохирч, бүрэн хэрэгжүүлж дуусан зүйлс аль алиныг багтаажээ. Малчдын гаргасан гомдлыг шийдвэрлэхийн тулд авсан бүх арга хэмжээг бүрэн тусгахын тулд л өмнө хийгдсэн эдгээр үүрэг амлалтуудыг 2017 оны 5 сарын Гэрээнүүдэд оруулсан. Цаг хугацааны хувьд тайлбар хийлгүйгээр тэдгээрийг ГТЗ-ийн явцын тайланд дурдсан нь бас л хэрэгжилт бодит байдлаас хурдан явагдаж буй мэт сэтгэгдэл төрүүлж байна. Бидний тооцож үзсэнээр хэрэгжсэн гэж буй 17 ажлын бараг хагас нь 2017 оны 5 сард Гэрээ байгуулахаас өмнө аль хэдийн хийгдсэн байжээ. Тэгэхээр 2017 оны 5 сараас хойш хийгдэх үүрэг амлалтын ердөө 9 нь буюу эсвэл 18% нь өнөөгийн байдлаар бүрэн биелсэн байна.

6 Хамтарсан мэдэгдэл, 2018.06.4–5 ГТЗ ба НОНХ-ны хурал.

ГТЗ-ийн өнөөдрийг хүртэлх ахиц дэвшил бол том амжилт гэдэгт эргэлзэх зүйл байхгүй. Гэвч юмыг хэтэрхий сайнаар харуулснаар Гэрээний үр өгөөжийг цагтаа хүртэх эсэхээс хэврэгхэн амьжиргаа нь шалтгаалах болоод байгаа малчдад бодит бус хүлээлт бий болгох эрсдэлтэй. Ийм учраас ГТЗ-ийн үйл ажиллагааг малчид хардах, үл итгэх асуудал ихэссэн байж болох юм (доор дахин хэлэлцэх болно). Түүнчлэн гомдлыг хаах эсэх хэрэгжилтийн ахицаас хамаарна гэж талууд тохирсон тул энэ нь Гэрээний хэрэгжилтийг хянаж буй ЭЗХНЗОГ-ын мониторингийг зогсоох өнгөц хий үндэслэл болж мэднэ.

Хэрэгжилтийн явцын талаар үнэн зөв сэтгэгдэл төрүүлэхийн тулд ГТЗ дөнгөж эхэлж байгаа болон дуусах дөхсөн ажлуудыг нарийн зааглаж, дуусаагүй байгаа ажлын гүйцэтгэлийн хугацааны талаар сүүлийн үеийн мэдээг олон нийтэд тайлагнаж байх хэрэгтэй.

Бүх талууд сонгон, өөрсдөө хянаж байх мэргэжилтнүүдийг гаднаас гэрээлж ажиллуулах нь нарийн төвөгтэй амлалтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй

Гэрээнүүдэд олон төрлийн өөр өөр төслүүдийг тусгасан тул ГТЗ хэрэгжүүлэх зарим ажлаа ажлын хэсгүүд ба бусад этгээдэд хариуцуулсан нь ойлгомжтой. Гадны мэргэжилтнүүд болон бусад талын дэмжлэг авснаар олон ажлыг нэгэн зэрэг хэрэгжүүлэхэд тустай, гэхдээ ГТЗ хэрэгжилтийг амжилттай гүйцэтгэхэд бүрэн хяналт тавьж, хариуцлагатай байдлыг хангахын тулд эдгээр харилцаа ямар болзол, нөхцөлтэй байхыг тогтоож өгөх шаардлагатай.

Хэрэгжилтийн эхний 6 сард орон нутгийн хөгжлийн томхон төслүүдийн ахиц тааруухан байсан бөгөөд техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, өмчлөлийн бүтэц, тогтвортой байдал зэрэг үндсэн асуудлуудыг шийдвэрлэхэд гаднаас мэргэжилтэн ажиллуулах шаардлагатай нь ГТЗ-д ойлгомжтой болж, ГТЗ Монголын “Хөгжлийн Шийдэл” ТББ-аас зөвлөгөө авахаар ханджээ. Энэ нь Ханбогд сумын иргэд жижиг бизнес байгуулахад туслалцаа үзүүлэн ажиллаж байсан хөдөөгийн хөгжлийн байгууллага бөгөөд малчны зах, нядалгааны шугам, малын тэжээл тариалах төсөл, худаг засварын төслийн техник эдийн засгийн үндэслэлийн судалгааг хийж өгөхөөр тохирчээ. Эдгээр техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа нь ГТЗ төсөл тус бүрээр дэлгэрэнгүй төлөвлөлтийн шийдвэр гаргах үндэс суурь болох юм.

Нөлөөлөлд өртсөн малчин Ганбат, Бямба нар малаа харуулдаж байгаа нь

Амжилт багатайн нэг жишээ бол байгаль орчны мониторингийн төсөл. ГТЗ мониторингийн ажлын хүрээг бүрэн тогтоохоос өмнө энэ төслийг нэгэн ТББ-д өгсөн нь ТББ-ын санал болгосон төлөвлөгөө тухайн ажлын зорилго, зориулалттай зөрчилдөх байдалд хүргэжээ. ГТЗ нарийн хяналт тавьж оролцохгүй бол энэ төсөл Гэрээний үүрэг амлалтыг хангаж чадахааргүй байна.

Хэрэгжилтийг цаг хугацаанд нь, амжилттай гүйцэтгэхэд гадны ТББ, мэргэжилтнүүд, гэрээт гүйцэтгэгч нарын туслалцааг авах нь тус нэмэртэй, зарим тохиолдолд бүр зайлшгүй шаардлагатай ч бас асуудал үүсгэх талтай. ГТЗ-ийн тал тус бүр гадны зөвлөхүүд сонгоход тэгш эрхтэй оролцох боломжтой байх ёстой. Ингэх нь шударга бөгөөд бүх талууд шинжээчид, тэдний дүгнэлтэнд итгэлтэй хандах нөхцөлийг бүрдүүлнэ. Төлбөрийн гэрээг ОТ эсвэл Говийн Оюу Сантай тусдаа шууд байгуулах байсан ч ГТЗ хэрэгжилтэнд туслуулахаар гэрээлсэн аливаа хувь хүн, аж ахуйн нэгжтэй тодорхой, тусгай харилцан ойлголцлын санамж бичиг (ХОСБ) юмуу өөр ямар нэгэн ажлын удирдамж баримт бичиг байгуулах шаардлагатай. ХОСБ, түүнтэй төстэй баримт бичигт холбогдох үүрэг амлалтын дагуу хийх ажлын хүрээг тодорхой зааж, Гэрээнүүдийн зорилгыг хангахын тулд ГТЗ бүрэн хяналт шалгалт тавина гэж тусгах хэрэгтэй. Мөн тухайн гэрээт аж ахуйн нэгж төслийг Гэрээний амлалт үүргийн дагуу хэрэгжүүлээгүй тохиолдолд юу болохыг ийм ХОСБ-т зааж өгсөн байх ёстой.

ГТЗ хэрэгжилтэнд дэвшилтэт аргаар хандах нь чухал

Хэрэгжилтэнд “Дэвшилтэт арга” ашиглах гэдэг нь хэрэгжилтийн явцад урьдчилан таамаглах боломжгүй сорилт тулгарсан ч тавьсан зорилгодоо сайтар хүрч, урт хугацааны тогтвортой үр дүн авчрах байдлаар Гэрээний үүрэг амлалтыг ойлгож, тайлбарлах явдал юм. 2017 оны 5 сард байгуулсан Гэрээнүүд нь Ханбогд сумын уламжлалт нүүдлийн мал аж ахуйг нэн хүнд байдалд хүргэсэн нарийн төвөгтэй, удаан хуримтлагдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилготой билээ. Эдгээр асуудлыг шийдвэрлэх амаргүй, урт хугацааны шийдлийг олж тодорхойлоход хугацаа шаардагдана. Мөн асуудлууд цагийн аясад өөрчлөгдөж мэднэ, тэгвэл шийдэл нь ч дагаад өөр болно. Тиймээс амжилттай хэрэгжүүлэхийн тулд бодит байдал өөрчлөгдөхөд хариу үйлдэл хийж чадахаар хангалттай уян хатан байж, Гэрээнээс чинагш амлалт үүргийн үндсэн зорилго, зориулалтанд төвлөрөх ёстой.

Зарим үүрэг амлалтын тухайд ГТЗ ийм маягаар ажилласан. Жишээ нь хувийн нөхөн олговрын багцын хүрээнд ОТ-с явуулж буй сургалтанд малчид хамрагдахад хүндрэлтэй тохиолдолд ГТЗ-ийн гэрээлсэн ТББ учирч буй бэрхшээлийг тодорхойлон, шийдвэрлэх алхмыг санал болгосноор хөтөлбөрийн үр өгөөжийг илүү олон малчин хүртэх боломжийг нээж өгчээ (Оруулга 1-ийг үзнэ үү: Ур чадвар олгох хөтөлбөрийн амжилт ба асуудлууд).

Түүнчлэн, Гэрээний зарим үүрэг амлалтыг нутгийн малчдад илүү өгөөжтэй байлгах арга зам эрэлхийлэхдээ дэвшилтэт арга ашиглахыг ОТ хүсч байгаа нь бидний судалгааны үеэр ажиглагдсан. ОТ-н төлөөлөгч хэлэхдээ анхнаасаа зорилтот бүлэгт чиглэсэн ажлуудыг илүү олон малчдад өгөөжийг нь хүртээх шаардлагатай тохиолдолд хүрээг нь өргөжүүлж болох юм гэж байлаа. Ахмад малчдад урамшуулал хөлс олгох ахмадуудтай мэдлэг хуваалцах төслийн талаар ярилцах үед ийнхүү хэлж байсан. Гэрээнд зааснаар энэ хөтөлбөр нь Ундай голын гольдролыг ОТ өөрчилсний улмаас нөлөөлөлд өртсөн ахмад малчдад л зориулагдсан боловч Ханбогд сумын бусад ахмад малчдыг хамруулахын тулд хөтөлбөрийн хүрээг тэлэх асуудлыг авч үзэж болох юм гэж ОТ-н төлөөлөл хэлж байлаа. Ярилцлагад үндэслэн хэлэхэд оролцогч ахмад малчдын урамшууллыг нэмэгдүүлэх талаар ГТЗ бас ярилцах хэрэгтэй, одоогийн байдлаар оролцогч ахмад малчдад сард олгох хөлсийг 100,000 төгрөг (ойролцоогоор 40 ам.долл.) байхаар төлөвлөжээ. Бэлчээр, усны хүртээмж улам хомсдоор байгаа нь ахмад малчдыг илүү эмзэг болгож байгаа, мөн тэд Гэрээнд заасан шинэ ур чадвар эзэмшүүлэх, амьжиргааны өөр хувилбар бий болгох гэх мэт амьжиргааг хөгжүүлэх боломжуудын ашиг тусыг сайн хүртэх боломжгүй. Ахмад малчдад туслах зорилготой цорын ганц үүрэг амлалт энэ тул илүү олон малчин хамруулж, ахмад малчдын амьжиргааг өөрчилж чадах хэмжээний хөлс олгох байдлаар төслийг өргөжүүлэх нь зүйтэй.

ГТЗ тухайн үүрэг амлалтын зорилгыг хангаж, урт хугацааны тогтвортой үр нөлөө бий болгохын тулд Гэрээг хэрэгжүүлэхдээ хаана дэвшилтэт арга шаардлагатай болохыг харгалзан үзэх хэрэгтэй. Богино хугацааны эсвэл нэг удаа хийгдээд өнгөрөх үүрэг амлалтын тухайд тэрхүү үүрэг амлалтын үндсэн зорилгоос шалтгаалан байнгын үйл ажиллагаа явуулах шаардлагатай эсэхийг харгалзан үзэж байх нь зөв. Хаягдлын далангаас Ундай голын ай савд учруулах нөлөөлөлд судалгаа хийх ОТ-н үүргийг жишээ болгон үзэж болж байна. Дээр өгүүлсэнчлэн, энэ үүргийн дагуу өнөөг хүртэл ердөө 2 хуудас хураангуй тайланг PowerPoint-ын 2 хуудас танилцуулгатай гаргаж өгчээ. Эдгээр материал нь малчдын хүлээж байснаас бага мэдээлэл агуулсан, дэлгэрэнгүй бус байтал ОТ уг үүрэг амлалтын биелэлтэнд энэ мэдээлэл хангалттай гэсэн байна. ГТЗ үүрэг амлалтууд (хаягдлын далангийн шүүрэл, түүнээс учирч болзошгүй нөлөөллийн талаарх мэдээллийг малчдад өгөх) болон нийт Гэрээний (Ундай гол ба усны ерөнхий нөөцөд учруулсан нөлөөллийн асуудлыг хамран малчдын гаргасан гомдлыг барагдуулах) язгуур зорилгыг хамгийн сайн илэрхийлж чадах тайлбарыг тохирох нь зүйтэй. Энэ нь нэг удаа танилцуулга өгөөд зогсох биш харин ГТЗ, нутгийн малчдад илүү дэлгэрэнгүй мэдээллийг тогтмол өгч байх гэсэн үг билээ.

Үүнтэй адил, гидрологийн үнэлгээнд тулгуурлан малчдад шинэ худаг барьж өгөх үүрэг амлалтанд наад зах нь хэдэн худаг барихыг заагаагүй ч Ханбогд суманд ойрын хугацаанд мал аж ахуй тогтвортой эрхлэхэд шаардлагатай тооны худаг гаргаж өгнө гэвэл энэ амлалтын хувьд Гэрээний үндсэн шалтгаан болох гомдлуудтай нийцсэн хамгийн сайн тайлбар болно.

Аливаа Гэрээг хэрэгжүүлэх явцад урьд нь мэдэгдээгүй хүндрэлүүд гардаг. ГТЗ дэвшилтэт аргыг өргөнөөр ашигласнаар нөхцөл байдлын өөрчлөлтийг түргэн мэдэрч, бодит хэрэгцээ шаардлагад зохицсон арга хэмжээг газар дээр нь авах боломжтой болно. Гэрээний үүргүүдийг бүрэн хэрэгжүүлж дуустал олон он жил болох тул иймэрхүү уян хатан байдал нь уул овоо мэт бэрхшээлийн дунд уламжлалт амьжиргаагаа залгуулах гэж зовж байгаа малчдад мэдэгдэхүйц үр өгөөж бий болгоход маш чухал ач холбогдолтой.

Малчдын өмчийн оёдлын хоршоолол

ОРУУЛГА 1

Ур чадвар олгох хөтөлбөрийн амжилт ба асуудлууд

Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн малчдыг тогтвортой амьжиргаа руу шилжүүлэх зорилготой нэг жилийн хугацаатай оёдлын сургалтын хөтөлбөрт 2016 оны эцсээс эхлэн 12 эмэгтэй малчин хамрагджээ. Тэдгээрээс 7 нь ур чадвараа орлогын эх үүсвэр болгохоор оёдлын бизнестэй болсон. Ингэхдээ хоршооны өмчлөлийн загвараар, ОТ-гоос гарааны бизнесийн санхүүжилт авч эхлүүлсэн байна. Тэд сургалт тун хэрэгтэй зүйл болсон, ОТ-гоос энгийн цүнх, даавуун цамц оёх анхны захиалгаа авсан гэж баяртай ярьж байлаа. Бизнес эрхлэхэд учирдаг бэрхшээлтэй тулгаран ажиллаж байгаа ч тэдний түүх бол амжилтын түүх – сургалтаар олж авсан ур чадвараа ашиглан бизнес эрхэлж, урт хугацааны амжилт, ашгийг зорьж буй малчдын жишээ гэдэгт тэд итгэлтэй байна.

Оёдлын сургалтанд хамрагдсан хүмүүс бүгдээрээ ийм амжилттай байсангүй. Өрх гэрийнхээ мал ахуйг авч явдаг хүмүүсийн тухайд сургалтанд суух дарамттай байсан, тэгээд ч тэр чадвараа ашиглаад бизнес хийе гэхэд хэдий таваараа мэт боловч юу болохыг таахын аргагүй, малаа байнга хариулж, дагаж байх шаардлагатай мал маллах ажилтай тохирохгүй гэж байв. Энд тэмдэглэхэд оёдлын сургалтанд суусан нэг эмэгтэй сургалт өөрт нь огт хэрэггүй зүйл байсан гэсэн. Бидний ярилцлага хийсэн бүх хүмүүс хэлэхдээ сургалтанд хамрагдаж буй хүн Сумын төвд байдаг уу эсвэл хөдөө малаа маллаж байгаа хүн үү гэдгээс сургалтын өгөөж шалтгаална гэж байв.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Хөгжлийн Шийдэлийнхэн ур чадварын сургалтаар олж авсан чадвараа ашиглах байдалд ийм их ялгаа байгааг тогтоон, оёдлын сургалтанд хамрагдсан малчид өөрийн биеэр, байнга ирэхгүйгээр хоршоололд оролцон, үр ашгийг нь хүртэх тогтолцоо бий болгохыг хичээж байна. Энэ нь оёдлын хоршооллын ажилд идэвхтэй оролцож чадахгүй малчид мөнгөн хөрөнгө оруулснаар хоршооллын хамтран эзэмшигч болж, аливаа орлогоос нь ноогдол ашиг хүртэх боломжтой гэсэн санаа юм. Тэдэнд ноогдох хувьцааны тоо хэмжээ нь оруулсан хөрөнгө мөнгө эсвэл хөдөлмөртэй нь хувь тэнцүү байх ба ингэснээр илүү идэвхтэй оролцож буй хүмүүсийн хөдөлмөртэй нь дүйцэх урамшууллыг шударгаар олгох явдал баталгаажна. Хоршооллыг байгуулахад ОТ-оос олгосон гарааны санхүүжилт сургалтанд оролцсон 12 хүнтэй бүлэгт нийтэд нь олгогдсон тул малчин тус бүрт мөнгөн дүнг хуваарилвал тухайн малчин хөрөнгө оруулах өөр эх үүсвэргүй байлаа ч гарааны хөрөнгө оруулалт хийх мөнгөтэй болох юм. Шинэ бизнест малчид оролцоход учирч буй эдгээр саад бэрхшээлийг тодорхойлон, шийдвэрлэх алхмуудыг хийхдээ тогтвортой амьжиргаатай болоход нь өрхүүдэд туслах гэсэн сургалтын хөтөлбөрүүдийн үндсэн зорилгыг хангахын төлөө уг ТББ ажиллаж байна.

Уламжлалт бууцны хажууханд ОТ-н барьж өгсөн тааруухан бууц

Эх Гэрээнүүд дэх тодорхой бус зүйлс цаашдаа асуудал дагуулж магадгүй

ГТЗ-ийн талууд 2017 оны 5 сард Гэрээнүүдэд гарын үсэг зурахдаа зарим үүрэг амлалтыг туршигдаагүй санал дээр үндэслэсэн тусгасан нь бүтэшгүй байж болох талтай. Энэ нь ГТЗ ба Гэрээний үр өгөөжийг хүлээж буй нутгийн малчид хэн хэнд нь урьдчилан таамаглах аргагүй бэрхшээл магадгүй бүр биелшгүй хүлээлт авчирч, урам хугарахад хүргэж болно.

Жишээ нь, малын тэжээл тариалах хөтөлбөр нутгийн малчдад чухал ач холбогдолтой, бодит үр дүн авчирна гэж ГТЗ найдлага тавьсан чухал үүрэг амлалт байсан, гэвч үүнийг Гэрээнд тусгахаас өмнө урьдчилсан судалгаа хийгээгүй. Харамсалтай нь саяхан хийгдсэн техник эдийн засгийн үндэслэлд хязгаарлагдмал усны нөөц болон бусад зардлын улмаас орон нутгийн нөхцөлд малын тэжээл тариалах боломжгүй гэж дүгнэжээ. Эх Гэрээнүүдэд уг төслийг хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд яахыг зааж өгөөгүй. Одоогийн байдлаар ГТЗ эдгээр төслүүдийг хэрэгжүүлэх аргагүй гэж шийдсэн тул тухайн зорилгыг хангаж, малчдад адил өгөөж хүртээж чадах өөр хувилбаруудыг дахин хэлэлцэн тохирох шаардлагатай.

Үүний нэгэн адил, дээр дурдсан гидрологийн судалгаагаар усны хомсдлыг шийдвэрлэх хангалттай хэмжээний усны нөөц тогтоогдохгүй бол ямар зохицуулалт хийхийг Гэрээнүүдэд зааж өгөөгүй. Гэрээнүүдэд ашиглалт багатай бэлчээрт шинэ худгууд гаргана гэж тусгасан, гэхдээ энэ нь зохих хэмжээний ус байгаа нь тогтоогдвол л хийгдэнэ гэсэн үг. Хэрэв гидрологийн судалгаагаар санал болгож буй шинэ худгуудыг гаргахад усны нөөц хангалтгүй хэмээн эцэслэн тогтоовол ГТЗ энэ үүрэг амлалтыг дахин хэлэлцэх шаардлага гарна.

Үүн дээр нэмж хэлэхэд, Гэрээнүүдэд гарын үсэг зурах үеэр талууд хэд хэдэн асуудлыг дараа тодруулахаар орхисон. Аль болох хурдан тохиролцоонд хүрч, хэрэгжүүлж эхлэх хүсэл тэмүүлэл нь ийм шийдвэр гаргахад хүргэсэн байх. Ярьж хэлцсээр дөрвөн жил гаруй болсон, тэгээд ч хэрэгжилт түргэн явагдаж байж малчид үр шимийг хүртэх байсан болохоор ингэж шийдсэн нь ойлгомжтой. Гэвч, талууд ийнхүү яарч, олон асуудлыг дараа хэлэлцэхээр үлдээснээр хэрэгжилтийг хүндрэлтэй болгожээ. Хэд хэдэн жишээг Оруулга 2-т, Шинжээчдийн Тайлан: Гэрээний үүрэг амлалтуудыг тайлбарлах нь гарчгаас үзнэ үү.

ГТЗ цааш урагшлахдаа Гэрээнүүдэд байгаа аливаа ойлгомжгүй зүйлийг зөрчил, бэрхшээлд хүргэхээс өмнө тодруулахыг хичээх нь зүйтэй. Түүнчлэн Гэрээний дагуу малчдын гомдлыг барагдуулах явдлыг хангахын тулд ГТЗ хэрэгжүүлэх боломжгүй эсвэл зорилгоос дэндүү тасархай үүрэг амлалтыг дахин хэлэлцэх шаардлагатай. Эцэст нь хэлэхэд, Гэрээнүүдэд оруулах аливаа өөрчлөлтийн талаар малчдад шуурхай, үр дүнтэй мэдээллийг тайлбарын хамт түгээж, эцэслэн шийдвэрлэхээс өмнө санал болгож буй өөрчлөлтийн тухайд тэдэнтэй зөвлөлдөн, саналыг нь авах боломж олгох хэрэгтэй.

ОРУУЛГА 2

Шинжээчдийн Тайлангууд: зөв ойлгож тайлбарлахын ач холбогдол

ГТЗ гэрээгээр ажиллуулсан Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн Тайлан (ХШБ-ийн Тайлан) ба Олон Талт Мэргэжлийн Шинжээчдийн Багийн Тайлангийн (ОТМШБ-ийн Тайлан) дүгнэлт, зөвлөмжүүдэд үндэслэн ГТЗ 2017 оны 5 сард гарын үсэг зурсан Гэрээнүүдийг боловсруулсан. Эдгээр тайлангуудад ОТ уурхайгаас Ундай гол ба усны бусад эх үүсвэрт учруулсан нөлөөллүүд болон ОТ-н нөхөн олговрын багц хэр хангалттай байсан тухайд дүгнэлт хийж, зөвлөмжүүд өгсөн.

Гэрээнүүдэд тусгасан олон үүрэг амлалт эдгээр зөвлөмжүүдээс урган гарсан, гэвч тэдгээрийг бодит ажил болгохын тулд юу хийх ёстойг Гэрээнүүдэд бүрэн гүйцэт, тусгайлан тодорхойлж чадаагүй. Үүний үр дагаварт эдгээр үүрэг амлалтууд амьдралд хэрэгжихдээ анхны зөвлөмж болон малчдын бодит хэрэгцээг хангаж чадахааргүй болж магадгүй байна.

Жишээ нь, ХШБ-ийн тайланд малчдад шинээр худаг барьж өгөх хөтөлбөр хэрэгжүүлэхийг зөвлөж, ус, бэлчээрийн хүртээмжийг сайжруулахын тулд Ханбогд суманд доод тал нь 75 худаг шинээр гаргах хэрэгтэй гэжээ.[7] Дээр дурдсанчлан, Гэрээнүүдэд гүний усны судалгаанд үндэслэн шинээр худаг барих үүрэг амлалт байгаа ч хичнээн тооны худаг барихыг тодорхой тогтоож өгөөгүй. Говийн Оюу Сангаар дамжуулан батлагдсан төслөөр Ханбогд суманд 12 худаг шинээр гаргах юм байна.[8]

Хамтын оролцоот мониторингийн хөтөлбөр үүний бас нэг жишээ. ОТМШБ-ийн Тайланд байгаль орчны мониторингийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, худгийн усны хэмжээ, чанар, тоос, бэлчээрийн чанар, хөрсний чийгшил, уурхайн хаягдлын байгууламжаас доошхи усны чанарын хяналт шинжилгээ зэрэг олон асуудлаар барьцтай, найдвартай, урт хугацааны мэдээ, өгөгдөл гаргадаг болох хэрэгтэйг тодорхойлсон.[9] Ажлын хүрээг ийнхүү тодорхой заасан байтал Гэрээнүүдэд шинээр хийгдэх мониторингийн зорилго, хамрах хүрээ, төрөл гэх мэт гол шийдвэрүүдийг хойш тавьжээ.[10] 2018 оны 8 сард гаргасан мониторингийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд зөвхөн ус, зэрлэг амьтад, ургамалжилт, агаарын чанарыг хамруулж, тус бүрээр нь цөөн тооны, өнгөц мониторинг хийхээр оруулсан, нийт зургаан мониторингийг сар тутам эсвэл илүү олон давтамжтай хийхээр төлөвлөж бусдыг нь үе үе л (жилд 1 удаа) хийхээр хуваарь гаргасан байна. Хамтын оролцоот мониторингийн хөтөлбөрийг анхандаа малчдын хувьд цалинтай ажлын эх үүсвэр болно гэж үзсэн ч байнгын хийх ажил нь ийм цөөхөн байхад арав гаруй малчинд хөдөлмөр эрхлэлтийн баттай эх үүсвэр болж чадна гэдгийг төсөөлөхөд бэрх. Тиймээс ГТЗ мониторингийн илүү баталгаатай, нарийн төлөвлөгөө гаргаж өгөх шаардлага тавьснаар одоо боловсруулж байна. Хөтөлбөрийн өндөр зорилтод хүрэхэд шаардлагатай сургалт, дадлага туршлага зэргийг хамарсан бүх талаас нь бодсон сайн төлөвлөгөө гаргахад талууд анхаарал тавих хэрэгтэй.

ОТМШБ-ийн Тайланд үндэслэсэн бусад үүрэг амлалтууд ч дутуу дулимаг хэрэгжих эрсдэлтэй. Аллювын усны нөөцийн судалгаа хийх зөвлөмж нь гүехэн гүний усны динамикийг илүү сайн ойлгох, гүний усны загварчлалыг сайжруулах, усны нөөцөд ирээдүйд учрах өөрчлөлтийг хэмжих суурь мэдээлэл бий болгох, ОТ-гоос усны нөөцөд учруулж буй нөлөөллийг тоогоор харуулах зорилготой. Ийм судалгаа нь малчид анхлан 2012, 2013 онд ЭЗХНЗОГ-т гомдол гаргасан үеэс хойш байсаар байгаа ОТ-н нөлөөллийн талаарх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхэд тус болно. Гэтэл Говийн Оюу Сангаар батлагдсан усны судалгаа эдгээр зорилтуудын алиныг нь ч гүйцэлдүүлэхгүй харагдаж байна, ГТЗ-д ч эдгээр асуудлыг шийдэхийн тулд ямар нэг судалгаа хийлгэх төлөвлөгөө алга. Чухал ач холбогдол бүхий энэ зөвлөмж ГТЗ-ийн шийдвэрлэх асуудлын гадна үлдчихсэн бололтой бөгөөд бидний ярилцсан ГТЗ-ийн төлөөлөгчид ч яагаад ингэснийг тоймтой хэлж мэдэхгүй байлаа.

Эдгээр үүрэг амлалтыг хэрэгжүүлэхийн тулд ГТЗ их зүйл хийх шаардлагатай. Эс бол Гэрээнүүд анх гарч ирсэн шигээ ач холбогдолтой зүйл биш байна гэж малчид үзэх болно. Ихэнх ажлууд дөнгөж эхлэлийн шатандаа байгаа тул ГТЗ тэдгээрийг хөндлөнгийн шинжээчдийн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх талаар илүү идэвх зүтгэл гаргахад оройтойгүй байна.

7 ОТМШБ/ХШБ-ийн Тайлан, х. 11.

8 Төслийн Тойм, БЭЛЧЭЭРИЙН ГАЗРЫН УСЖУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ “ХҮСЭЛ ГҮЙЦЭЛДҮҮЛЭГЧ” ТӨСӨЛ, Төслийн үр дүн, х. 2.

9 ОТМШБ/ХШБ-ийн Тайлан, х. 25, Мониторингтой холбоотой зөвлөмжүүд #1

10 Гэрээ1, Хавсралт 1, хэсэг 3.1.1.

Говийн Оюу Сангаар дамжуулан санхүүжилт хийгдсэнээр хэрэгжилт улам хойшилж, хамрах хүрээ нь өөрчлөгдөж болзошгүй

Гэрээний үүрэг амлалтын дийлэнхэд ихээхэн санхүүжилт шаардлагатай бөгөөд ОТ ихэнхийг нь Говийн Оюу Сангаар дамжуулах хүсэлтэй. Санхүүжилтийн ийм загвар хэрэгжилт удаашрах, хийх ажлын цар хүрээ өөрчлөгдөх, ГТЗ-ийн хяналт дутах зэрэг томхон эрсдлүүдийг дагуулна. Ингэснээр төслүүд урагшлахад саад учрахын зэрэгцээ уг Сан ганц Ханбогд сум бус нийт Өмнөговь аймагт хөгжлийн санхүүжилт олгохоор байгуулагдсан тул улс төрийн агуулгатай ч болж мэднэ.

ОТ болон сум, аймгийн түвшний засаг захиргааны төлөөлөл бүхий Сангийн Төлөөлөн Удирдах Зөвлөл улирал бүр төслүүдэд санхүүжилт баталдаг.[11] Тиймээс ОТ санхүүжилтийн санал оруулан, зарим үед авч хэлэлцэхийг нь түргэтгэж чадах ч аливаа нэг төсөл батлагдана гэдгийг амлах юмуу баталгаа өгч чадахгүй, хэрэгжилтийн хугацаа болоод Өмнөговь аймгийн бусад хөгжлийн төслүүдтэй харьцуулж эрэмбэлэх бол ОТ хяналт тавих боломжгүй билээ. Ийм нөхцөл байдал аль хэдийн зарим нэг хэрэгжилтийг түдгэлзүүлсэн. Жишээ нь эрүүл малчны хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлнэ гэж товлосон ч нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөрийг илүү чухал хэмээн үзсэн тул 2019 хүртэл хойшлуулсан байна.

Үүний нэгэн адил усны судалгаа батлагдахаасаа өмнө нэг бус удаа хойшлогдож байв. Батлагдсан хувилбарт судалгаанд үндэслэн 2018 оны 4-р улиралд[12] Ханбогдод худгууд барина гэж заасан ч дахиад хойшлон 2019 он гаргаж байж хэзээ ч юм эхлэхээр бололтой. Түүнчлэн усны судалгаа, худаг барих төслөөс харахад үүрэг амлалтын санхүүжилтийг Говийн Оюу Сангаар дамжуулснаар зарим төслийн зорилго, цар хүрээ өөрчлөгдөх бий гэдэг асуудал тавигдаж байна. Оруулга 2-т дурдсанчлан, батлагдсан төслөөр Ханбогдод ердөө 12 худаг барина гэсэн нь ОТМШБ-ийн Тайланд 75 худаг гэснээс хол зөрж байна. Үүнээс гадна ойролцоох

ОТ-н усны сав

гурван сумыг худаг барих төсөлд хамруулахаар саналд тусгасан нь нийт Аймагт зориулсан Сангаас санхүүжилт батлуулахын тулд ийм буулт хийхэд хүрсэн байх талтай.

Нэмж хэлэхэд, энэ төслийн санхүүжилт Говийн Оюу Сангаас хийгдэж буй тул гүйцэтгэгч нь Харилцан ойлголцлын санамж бичгийг шууд ГТЗ-тэй байгуулаагүй. Тэгэхээр төслийн хамрах хүрээг өөрчлөх хувилбар одоо бүр ч хязгаарлагдмал болсон бөгөөд ГТЗ гүйцэтгэлийн хугацаа, худгийн байршил зэрэг чухал асуудлаар хяналт тавьж чадахгүй.

Гүйцэтгэлийн хугацаа, төслийн цар хүрээ, ГТЗ-ийн хяналт зэрэг үүрэг амлалтын хэрэгцээг тухайн зохицуулалт хангаж чадахаар бол, мөн уг Сангийн Аймгийн хэмжээний хөгжлийн зорилтуудтай тэрхүү зохицуулалт зөрчилдөхгүй байгаа тохиолдолд л Гэрээний үүргийн санхүүжилтийг Говийн Оюу Сангаар дамжуулж болох юм. ГТЗ Говийн Оюу Санд найдсан хэвээр байх аваас ОТ, орон нутгийн засаг захиргаа Сангийн ТУЗ-д байгаагаа ашиглан, эцэслэн батлагдсан төслүүдийн цаг хугацаа, хамрах хүрээг хэвээр байлгаж, ГТЗ хангалттай хяналт тавих явдлыг хүлээн зөвшөөрүүлэх хэрэгтэй.

11 11 Говийн Оюу Сангийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг http://www.goviinoyu.mn/eng/. Сайтаас үзнэ үү.

12 Төслийн Тойм, БЭЛЧЭЭРИЙН ГАЗРЫН УСЖУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ “ХҮСЛИЙН ЭРДЭНЭ” ТӨСӨЛ, Төслийн үр дүн, х. 2.

ГТЗ-ийн талуудын чадавх, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай

Ярилцлага хийж байхад хэд хэдэн хүн чадавхийн асуудлаас болоод зарим зүйлийн хэрэгжилт хойшилсон буюу хүндрэл учирсан гэж байв. Чадавхийн асуудал ялангуяа орон нутгийн засаг захиргаа, малчдын төлөөлөгчдөд хамааралтай байна.

Засаг Захиргааны Чадавх

Ханбогд сумын засаг захиргаа ажилтнуудаа өөрсдийнх нь хариуцсан ажлын хажуугаар ГТЗ-д томилон ажиллуулж байна. Сумын засаг захиргааны ажиллагсдын дийлэнх нь Гэрээг хэрэгжүүлэх явдал бол ГТЗ-д засаг захиргааг төлөөлж буй албан тушаалтнуудын үүрэг гэж үздэг. Бид ярилцлага хийж байхад сумын засаг захиргааныхны дунд тэдгээр хүмүүсээс бусад нь ГТЗ-ийн зорилго, үүрэг хариуцлагын талаар нарийн ойлголтгүй байлаа. Сумын засаг захиргааны тогтолцооны мэдлэг, хариуцлага харьцангуй сул байгаа нь яах аргагүй Гэрээний үүргийг хэрэгжүүлэх явдлыг хүндрүүлж байгаа ба ГТЗ дэх сумын засаг захиргааны төлөөллийн аливаа өөрчлөлт засаг захиргааны оролцооны чадавхад ихээхэн нөлөөлдөг гэсэн үг.

Тийм ч учраас ГТЗ дэх засаг захиргааны төлөөлөл саяхан өөрчлөгдсөн нь нэлээд асуудал дагуулсан. Засаг захиргааг удаан төлөөлж буй төлөөлөгчдийн нэг байсан сумын мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга 2018 оны эхээр нас барсан тул ялангуяа засаг захиргаа тэргүүлж оролцвол зохих бэлчээртэй холбоотой ажлууд хойшлогдсон. Мөн 2018 оны эхний хагас жилд Ханбогд сумын захиргааны бүтэц өөрчлөгдөн, ГТЗ-ийн дарга хийж байсан сумын засаг даргын орлогч зэрэг дээд албан тушаалтнууд солигджээ. Засаг захиргааны бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт гарах нь харьцангуй ердийн үзэгдэл бөгөөд энэ нь аль нэг намд гарсан улс төрийн сэлгээ, орон нутгийн сонгуультай холбоотой явагддаг. 2020 онд болох дараагийн сонгуулиар бас л өөрчлөлт гарах байх, гэвч эрх баригч намын засаглал өөрчлөгдвөл халаа сэлгээ өмнө ч явагдаж магадгүй. Цаашид засаг захиргааны ажилтнууд өөрчлөгдсөнтэй холбоотой үүсэх асуудлаас зайлсхийх, түүнчлэн хэрэгжилтийн ачааг жигд хуваарилах үүднээс зөвхөн ГТЗ дэх төлөөллөөс гадна ер нь сумын засаг захиргааны нийт газар, хэлтсүүд нь Гэрээний хэрэгжилтийн талаар мэддэг, идэвхтэй оролцдог болгох ажлыг ГТЗ санаачлага гарган хийх шаардлагатай.

Ярилцлага өгсөн олон хүн сумын засаг захиргааны зүгээс хийх ажлууд хойшилсон нь санхүүжилт багатайгаас болсон гэж байв. Ханбогд сумын нутаг дэвсгэрт дэлхийд томд орох зэсийн уурхай үйл ажиллагаа явуулж, сумын өөрийнх нь хүн амаас илт давсан тооны түр ажиллагсад ирж байна. Үүний улмаас хог, тоос, Хятад руу хүдэр байнга зөөж байгаа том оврын тэрэгний утаа зэрэг нийгэм, байгаль орчны асуудал учирч байна. Гэтэл орон нутгийн засаг захиргаанд хуваарилан өгдөг төсөв, хүний нөөцөд энэ бүхнийг харгалздаггүй. ОТ-н усны төлбөрийн хураамжийн зарим хэсгийг сум руу өгөх асуудлаар Аймагтай хэлэлцэж тохирохыг Гэрээний нэг үүрэг болгосон нь иймэрхүү чадавхийн асуудлыг шийдвэрлэхэд туслах зорилготой юм. ГТЗ энэ үүргийг хэрэгжүүлэхэд эн тэргүүний ач холбогдол өгөх хэрэгтэй бөгөөд сумын санхүүжилт нэмэгдсэнээр бусад үүрэг амлалтыг хэрэгжүүлэх явдлыг түргэсгэн, сайжруулах болно. Хэрэв энэ үүрэг амлалт хэрэгжихгүй бол сумын засаг захиргааны хүч чадал, нөөц бололцоог сайжруулах өөр арга арга зам юу байж болохыг талууд авч хэлэлцэх хэрэгтэй.

Малчдын Төлөөлөгчдийн Багийн Чадавх

ГТЗ-д байгаа гурван талаас зөвхөн Ханбогд сумын малчдыг төлөөлж буй Малчдын Төлөөлөгчдийн Баг (МТБ) ямар нэг цалинтай ажил хийлгүйгээр оролцдог. МТБ-ийн гишүүд орлого олох ажлынхаа хажуугаар ГТЗ-ийн өргөн үүрэгт ажлаа хийхэд цаг гаргах хэрэгтэй болдог. Малаа маллаж байгаа хүмүүс ГТЗ-ийн хурал болдог Ханбогд сумын төвөөс алс хол малаа даган явдаг тул энэ нь нэлээд хүндрэлтэй.

ГТЗ-ийн гишүүд үүрэгт ажлаа хийх завгүй болбол идэвхгүй гишүүдийг солих эсвэл нэмж гишүүд сонгон, үүрэг хариуцлагыг тараан хуваах хувилбар байж болно. Улирал тутам болдог багийн хурлын үеэр нутгийн иргэд МТБ-ийн гишүүдийг сонгох буюу дахин баталдаг, гэвч засаг захиргааны саяхны өөрчлөлтийн улмаас 2017 оны өвөл, 2018 оны хавар болох байсан багийн хурлууд хийгдээгүй. 2018 оны 9 сард багийн хурлууд болж, нутгийн иргэд МТБ-т гурван шинэ гишүүн сонгосон . Удалгүй ГТЗ идэвхгүй, хуралдаа ирэхээ больсон гурван гишүүнийг халжээ. МТБ-т удаан ажиллаж буй гишүүд шинэ гишүүдтэйгээ ажиллаж, ГТЗ-ийн талаарх өөрсдийн туршлага, мэдлэгээ хуваалцан, хэрхэн яаж ажилладгыг танилцуулж, цаашид хэрэгжилтийг хангахын тулд хүн бүрийн тодорхой чадварыг хамгийн сайн ашиглах арга замыг олох хэрэгтэй. МТБ-ийн бүх гишүүд ажилласан хугацаанаас шалтгаалахгүйгээр нийт малчин түмний дуу хоолой, хэрэгцээ шаардлагыг төлөөлөхийн тулд идэвхтэй хамтран ажиллах нь чухал.

Гэрээний хэрэгжилтийн үр өгөөжийг хүртэхийг хүсч буй малчдын тавьсан хоёр дах асуудал нь одоо хэр нь малаа маллаж байгаа хүмүүсийн төлөөлөл МТБ-т цөөхөн байгаа тухай байв. Ингэснээр малаа малласаар байгаа малчдад учирч буй асуудал, тэдний санаа бодлыг дутуу ойлгох вий хэмээн эмээж явдгаа зарим малчид хэлж байлаа. Ийм болгоомжлол нь Гэрээний хэрэгжилтийн өгөөжийг энэ явдалд түлхүү оролцсон, амьжиргааны өөр хувилбар бий болгох боломжтой өрхүүд л хүртэх байх гэсэн хардалт үүсгэдгийг дараагийн хэсэгт авч үзэх болно. Гэвч олон үүрэг хариуцлага хүлээсэн, цаг хугацаатай ажилд малаа маллаж байгаа хүмүүс оролцоход хүндрэлтэй. Тэгэхээр Гэрээний хэрэгжилт, ГТЗ-ийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй, Малчдын Зөвлөлдөх Хороог байгуулах асуудлыг ГТЗ авч үзэх нь зүйтэй. Ингэвэл малаа маллаж буй хүмүүс МТБ-ийн цаг хугацаат үүрэг бүхий гишүүнчлэлд хамрагдахгүйгээр ГТЗ-ийн үйл ажиллагаанд илүү үүрэг гүйцэтгэх боломжтой болох юм.

ГТЗ итгэлтэй харилцаа үүсгэхэд ахиц гаргасан

Өнгөрсөн 18 сарын хугацаанд ГТЗ дэх талуудын хоорондын итгэлцэл, харилцаа ихээхэн сайжирсантай талууд нийтдээ санал нэгтэй байна. Эхний зургаан сарын ноцтой удаашралтай харьцуулахад гүйцэтгэл сүүлийн үед хурдасч, урагшилсан нь энэхүү өсөн нэмэгдэж буй итгэлцлийн ач тус гэж зарим тал үзэж байна.

Итгэлтэй харилцаа үүсгэсэн нь маш том амжилт бөгөөд үүнийг сахин хадгалах нь мөн адил ач холбогдолтой. Гэрээг хэрэгжүүлэхийн тулд ГТЗ-ийн хийх ажил тун их. Түүнээс цааш ч ГТЗ хагас-байнгын байгууллага байдлаар ОТ уурхай ажиллах 50 гаруй жилд ажиллан, малчид ба уурхайн хооронд үүсэх асуудлуудыг шийдвэрлэх өргөн үүрэгтэй. ГТЗ-ийн гишүүдийн хооронд итгэлцэл бий болгож, түүнийгээ хадгалах нь ГТЗ цаашид тулгарах саад бэрхшээлийг даван туулах чадвартай болоход шийдвэрлэх нөлөөтэй. Харилцаагаа жинхэнэ тогтвортой болгохын тулд өнөө бий болсон итгэлцлийг одоогийн ГТЗ-ийн гишүүдээр зогсохгүй улмаар нутгийн олон нийтийн итгэлийг мөн олж авах хэрэгтэй.

Нарны зай хураагуур суурилуулсан уламжлалт Монгол гэр

Дараагийн хэсэгт дурдсанчлан, нийт иргэдийн итгэлийг олохын тулд ГТЗ улам их ажиллах ёстой. ОТ уурхай, ГТЗ, Гэрээний хэрэгжилтийн явц зэргийн талаарх малчин өрхүүдийн төсөөлөл янз бүр байна. Ирэх саруудад ГТЗ нутгийн иргэдтэй итгэлтэй харилцаа бий болгох, ялангуяа Гэрээний амжилттай хэрэгжилтийн үр өгөөжийг тэдэнд харуулах, өөрийн гишүүдийн хоорондох итгэлцлийг сайжруулахад төвлөрч ажиллах нь зүйтэй.

Нөлөөлөлд өртсөн малчин Цэвээн

МАЛЧДЫН ОЙЛГОЛТ

Ерөнхийд нь авч үзвэл ГТЗ-ийн гишүүдтэй харьцуулахад эхний 18 сарын хэрэгжилтийн явцын тухайд малчид нийтдээ эерэг бодолтой биш байна. Ойлголтын энэ ялгаа нь, нэг талаар, Гэрээнүүд болон тэдгээрийн хэрэгжилтийн талаар нийтэд хүртээмжтэй мэдээлэл бага байгаатай холбоотой байж болох юм. Нэмж хэлэхэд зарим малчид Гэрээний үр өгөөжийг хэн хүртэх тухай тодорхой асуудлыг хөндөж байв. Гэхдээ бид Гэрээний томхон үүрэг амлалтыг тайлбарлаж өгсний дараа амжилттай хэрэгжүүлж чадвал эдийн засгийн байдал нь өөр өөр, төрөл бүрийн ажил мэргэжил бүхий нутгийн өрхүүдэд үр өгөөжөө адил хүртээх юм байна гэдэгтэй санал нэгдсэн.

ГТЗ-ийн харилцаа холбооны сул байдал

Бидний судалгаагаар ГТЗ гадагшаа өргөн олон нийттэй хийж буй харилцаа холбоо дутагдалтай байгаа нь сул тал гэж гарсан. 2018 оны 6 сард бидний ярилцсан малчдын олонх нь Гэрээнүүдийн тухай сайн мэдэхгүй байв. Тэдгээрийн тухай сонссон гэж буй хүмүүс ч бүх үүрэг амлалт болоод өөрсдөө хүртэж болох олон талын үр өгөөжийн талаар ойлголтгүй байлаа.

Хамааралтай талуудтай хийсэн ярилцлагаас харахад Гэрээнүүд, тэдгээрийн хэрэгжилтийн байдлын талаар малчид мэдэхгүй байгаад хэд хэдэн шалтгаан байж болж байна. Нэгдүгээрт, орон нутгийн нөхцөл байдал, малчдын амьдралын уламжлалт хагас-нүүдлийн хэв маяг харилцаа холбоо барихад нэлээд бэрхшээлтэй. Хэрэгжилтийн талаар мэдээлэл түгээх үндсэн арга нь айл айлаар орох байдлаар хувь өрхүүдээр явах бөгөөд айлууд хоорондоо зайтай байдаг тул шатахууны зардал, Говь нутагт өртөг ихтэй тусдаг машин тэрэгний элэгдэл эвдрэл зэргээс гадна цаг хугацаа их шаардагддаг. ГТЗ-ийн нэг гишүүн мэдээлэл сайн түгээх явдал цаг хугацаа, хөрөнгө мөнгөөр хязгаарлагддаг гэж байлаа. ГТЗ мөн улирал тутам болдог, харьцангуй олон хүн цугладаг цөөхөн арга хэмжээний нэг болох багийн хурал дээр сүүлийн үеийн мэдээлэл хийдэг. Гэвч бараг жил шахуу хурлууд хойшилсон нь малчидтай үр дүнтэй харилцахад тулгарч буй бэрхшээлтэй байдлыг улам дордуулжээ.

Хоёрдугаарт, ГТЗ-ийн зарим гишүүдийн үзэж байгаагаар ГТЗ албан ёсны хамтарсан мэдэгдэлдээ найддаг нь Гэрээнүүдийн хэрэгжилтийн талаар мэдээлэл түгээх тэдний боломжийг хязгаарлаж байна. ГТЗ-ийн хурлаар талууд ГТЗ-ийн ажлын явцын тухай шинэчилсэн мэдээ бүхий хамтарсан мэдэгдэл гаргахаар тохирдог. Эдгээр мэдэгдэл ихэнхдээ тал хуудас эсвэл хоёр хүртэлх хуудас байх ба үйл ажиллагаа тус бүрээр товч мэдээлэл агуулдаг. Уг нь улирал тутам болдог ГТЗ-ийн хурал болгоны дараа ийм мэдэгдэл гаргах ёстой, гэхдээ маш их оройтож гардаг. Хэрэв ГТЗ-ийн гишүүд зөвхөн мэдэгдэлд дурдсан зүйлийг л хуваалцахаар хязгаарлагдвал малчдын тавьсан бүх асуултанд хариулт өгөх юмуу тухайлсан малчны нөхцөл байдлыг хэлэлцэх, үүрэг амлалт тус бүрийн талаар дуртай цагтаа сүүлийн үеийн мэдээлэл өгч чадахгүйд хүрдэг бөгөөд энэ бүгд үр дүнтэй харилцааг ихэд хүндрүүлдэг. Гэрээнүүдийг хэлэлцэж байх үед цуу яриа гарахаас сэргийлэн, талуудад тохиролцоогоо ахицтай урагшлуулах боломж олгохын тулд ГТЗ дээр юу яригдсан талаар өгөх мэдээллийг хязгаарласан нь тэр үедээ зөв байсан байж болох юм. Гэвч эдгээр үндэслэлүүд Гэрээний хэрэгжилтийн шатанд хамааралгүй байтал ГТЗ-ийн үйл ажиллагааг тойрсон нууцлаг байдал өөрчлөгдөх нь удаашралтай байна.

Гадагшаа харилцаа холбоо тааруу байх нь хэд хэдэн шалтгааны улмаас өөрөө том асуудал юм. Хэрэгжилтийн талаар мэдээлэх харилцаа холбоо сул байгаагаас (магадгүй өмнө дурдсан ихэнх үүрэг амлалтын хувьд анхнаасаа бодит бус цаг хугацаа тавьсантай нийлээд) зарим малчдыг ГТЗ болон Гэрээнүүдийн хэрэгжилт үр дүнтэй эсэхэд тэр ч байтугай бодитой эсэхэд нь эргэлзэхэд хүргэж байна. Нэмж хэлэхэд, ерөнхийдөө ил тод байдал дутмаг, гадагшаагаа харилцах найдвартай тогтолцоо байхгүйгээс Гэрээний үр өгөөжийг дотнын хүмүүстээ хүртээж байна гэсэн бодит эсвэл таамаг бодол үүсгэж болох юм. Сүүлийн үеийн мэдээллийг түгээх зохистой систем байхгүй тул ГТЗ-ийн гишүүд тэдэнтэй ойр байдаг эсвэл мэдээлэл олж авахаар идэвхийлж буй иргэдтэй илүү ойр ойрхон харилцах нь мэдээж. Энэ нь эдгээр бүлэгт ороогүй хүмүүст зориудаар өөрсдийг нь хассан мэт сэтгэгдэл төрүүлнэ. Зарим малчид үр өгөөжийг хуваарилах шийдвэрийг яаж гаргадаг нь сэжигтэй гэж байв.

Эцэст нь хэлэхэд, хэрэгжиж буй үүрэг амлалтын цар хүрээний талаар мэдээлэл байхгүйгээс айл өрхүүд Гэрээнээс өөрсдийн хүртэх үр өгөөжийн тухайд бодит бус хүлээлттэй болж улмаар сүүлд нь ямар ч утгагүй урам хугарахад хүргэж болзошгүй. Жишээ нь Ханбогдод шинэ худгууд гаргана гэснийг сонсоод олон хүн чих тавьж байгаа, гэтэл ашиглалтгүй бэлчээрийн бүст барихаар санал болгож буй худгийн тоо малчдын хүлээлтийг хангаж чадах эсэх нь эргэлзээтэй.

ГТЗ ил тод байдал ба гадагшаа харилцах ажиллагаанд ихээхэн хүч хөрөнгө гаргах хэрэгтэй. Үүрэг амлалт тус бүрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бүхий сүүлийн үеийн мэдээг малчдад тогтмол өгч байх нь зүйтэй. ГТЗ тодорхой мэдээллийг хуваалцахгүй байх шалтгаан зааснаас бусад тохилдолд хэрэгжилтийн талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй байх ёстой. Бидний ярилцсан малчид фейсбуук мессеж, айлаас-айлд очих, багийн хурлууд гэх мэт холбоо харилцаа барих аман болон бичгийн янз бүрийн аргыг илүүд үзэж байсан. Гадагшаа харилцаа холбоо барих системтэй арга бий болгохын тулд харилцаа холбооны олон хэлбэрийг хослуулан ашиглах нь зөв.

Гэрээний үр өгөөж яг авбал зохих хүмүүстээ хүрэх ёстой

Ядмаг харилцаа холбооны асуудлыг орхиод хэлэхэд зарим малчид бусдыгаа бодвол Гэрээний өгөөжийг сайн хүртэнэ гэсэн бодолтой байна. Энэ нь хэд хэдэн шалтгаантай. Уламжлалт амьдралын хэв маягаа үргэлжлүүлэх бодолтой зарим малчид хэлэхдээ хөдөө амьдардаг хүмүүс Гэрээний өгөөжийг хүртэхэд бэрх, тийм болохоор сумын төвд амьдардаг — малаа өөрсдөө малладаггүй, хүн хөлсөлж маллуулдаг хүмүүс л хүртэнэ гэж байв. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зээл, мэргэшүүлэх сургалт (сургалтын хөтөлбөрүүдтэй холбоотойгоор энэ асуудлыг хөндсөнийг Оруулга 1-ээс үзнэ үү) гэх мэт амьжиргааг төрөлжүүлэх замаар малчдад өгөөжийг нь хүртээх зорилготой олон үүрэг амлалтын тухайд ийм шүүмжлэл гарч байлаа.

Ярилцлага өгсөн зарим хүмүүс худаг барих, засварлах, байгаль орчны хамтын оролцоот мониторинг гэх мэт малаа үргэлжлүүлэн маллах бодолтой айл өрхөд зориулсан ажлын байр бий болгох хөтөлбөрүүд хэр хүртээмжтэй талаар асууж лавлаж байсан. Шинэ худаг баригдсан эсвэл засвар үйлчилгээ хийхээр болсон худагтай газар ийм асуултууд гарах шинжтэй. Тодорхой тогтоосон тооны малчин өрхөд өгөөжөө өгөх эдгээр бүх хөтөлбөрийн тухайд ГТЗ хэн үр өгөөжийг нь хүртэхийг сонгох шударга, ил тод үйл явцыг тодорхойлж, ойлгомжтой мэдээлэх нь тун чухал.

Ахмад малчин өрхүүд мөн Гэрээний хэрэгжилтийн гадна үлдэх байх гэж зовниж буйгаа илэрхийлж байв. Нас өндөр болсон малчид шинэ ур чадварт суралцан, шинэ амьжиргаатай болох боломжгүй, амьжиргааны өөр хувилбар бий болгох хөтөлбөрийн өгөөжийг хүртэх чадварын хувьд хамгийн их хязгаарлагдмал байх талтай. Жишээ нь нэг настай малчин шинээр нөхөн олговор авах шалгуур хангасан, гэхдээ сонго гэж санал болгосон зүйлс өөрт нь тус болохоргүй юм гэж байлаа. Нөхөн олговрын багцанд буй сургалтын хөтөлбөр, гарааны бизнесийн дэмжлэг, эсвэл мал гэсэн мөнгөн бус төрөл бүрийн хэлбэрээс малчид сонгож болно. Тэр малчны хувьд нас өндөр учраас сургалтанд суугаад, гарааны бизнес эрхэлж чадахгүй тул мал авах л ганц бодит хувилбар байсан гэсэн. Гэвч тэрээр малаа сайн хариулж чадахаа больсон болохоор энэ ч бас зөв туслалцаа биш гээд, хүүхдүүдэд мал маллах дарамт ирнэ, нөгөө талаар

Нөлөөлөлд өртсөн малчин Наранцэцэг

ус, бэлчээр хомсдсон болохоор хэдэн мал яадаг бол гэж санаа зовж байна гэж байлаа. Саяхны судалгаагаар Говийн энэ бүст бэлчээр, усны хүртээмж доройтон, дийлэхээргүй их малтай болсон гэж гарсан. Мал нэмж өгөх нь энэ асуудлыг улам дэвэргэнэ, магадгүй малчид ямар ч үнэ цэнэгүй хэдэн амь тавьсан малтай хоцорч мэдэх юм. Тэр настай малчин тэрний оронд мөнгө өгвөл аваад, эмчилгээний зардлаа төлмөөр байна гэж байлаа.

Ган гачиг, зуд, үер гэх мэт байгалийн гамшгийн улмаас эмзэг байдалд орсон өрхүүд мөн Гэрээний өгөөжийг хүртэх боломж муутай байж магадгүй. Энэ асуудлын талаар Оруулга 3 -г үзнэ үү.

Малаа малласаар байгаа ялангуяа настай, эмзэг бүлгийн малчид үр өгөөжийг хүртэж чадахгүй орхигдох эрсдэл өндөр байна. Энэ нь өмнө дурдсан харилцаа холбооны асуудалтай холбоотой, сумын төвөөс алс амьдардаг, тэр болгон ирж очоод байх боломжгүй малчидтай холбоо барих тун хүндрэлтэй. ГТЗ Гэрээний үр өгөөжийг хүртэхэд нь ямар саад төвөг байгааг малчдаас лавлаж тодруулан, эдгээр бэрхшээлүүдийг даван туулах арга замыг идэвхтэй эрэлхийлэх шаардлагатай.

Ус, бэлчээр нь хомсдсон тэмээд

ОРУУЛГА 3

Онцгой байдлын хэрэгцээ шаардлага ба Гэрээнүүд

2018 оны 6 сард бид Ханбогдод очиход маш их гантай, өмнөх жилийн 8 сард үер болох хэмжээний бороо орсноос хойш хур тунадас бараг буугаагүй байдалтай байв. Бидэнтэй ярилцсан малчдын олонх нь уурхайн усны хэрэглээ өндөр, түүнчлэн өмнө бэлчээр байсан газрыг ашиглаж, доройтуулсан нь ус, бэлчээрийн хомсдлыг улам гааруулсан гэж байлаа.

Бид ярилцлага авсан олон өрх малаа тоо толгой бүрэн байлгах, амьжиргаагаа залгуулах гэж зүдэрч байгаа нь илт байв. Нэлээд хүнд байдалтай байгаа өрхүүдийн зарим нь Гэрээнүүд, тэдгээрээс өөрсдөд нь ирэх үр өгөөжийн талаар ойлголтгүй байна. Зарим нь хэрэгжилт удаан, хямралтай үед нэмэр болох бодит үр дүн дутмаг байгаад цухалдаж буйгаа илэрхийлж байсан.

Жишээ нь нэг ярилцлагыг бид өлсгөлөн тэмээдийн буйлаан дор хийсэн. Бэлчээрийн хүрэлцээ муугаас хоёр жил дараалан тэмээд нь тарга аваагүй, эрүүл мэндийн хувьд ч сайнгүй болсон гэж тэр айлынхан тайлбарлаж байв. Үүний үр дагаварт мал сүрэг нь ихэд хорогдсон. Өөр нэг айлын бэлчээр энэ жил малын сэгээр дүүрсэн гэв. 2018 онд ямаа, хониноосоо 70–80 төл авсан ч 6-гаас бусад нь, мөн дээр нь 150 орчим том мал хорогджээ. Малын бэлчээр, ус ховордсон тул 110 орчим адуу, тэмээгээ зарахад хүрсэн байна. Хэдхэн жилийн өмнө энэ айлд ирэхэд мал сүрэг нь өнгөлөг, төл нь эрүүл, өөрсдөө ч ОТ-той зэрэгцээд хөгжиж дэвжинэ гэсэн бодолтой байсантай нь харьцуулахад өнөөгийн байдал тэс өөр болжээ. Тэр хоёр айлын ойр хавьд малын бэлчээр, ус хангалтгүй. Амьжиргаагаа залгуулдаг ганц мэддэг юм нь мал маллах, гэтэл сүүлийн жилүүдэд мал сүргээрээ ам бүлээ тэжээж, тогтвортой амьжиргаа залгуулж чадахгүйд хүрч, аргаа барж сууна гэцгээж байлаа.

Хямралтай үед эмзэг өрхүүдийн нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг Гэрээний өгөөжтэй холбож, дэмжлэг туслалцаа үзүүлэх арга замаа ГТЗ тодорхойлох шаардлагатай. Гэрээнүүдийн үр өгөөжийг хүртэх боломжийн талаар мэдээлэл түгээхийн зэрэгцээ хамгийн эмзэг байдалд буй өрхүүдийн хэрэгцээ, тэдэнд тулгарч буй бэрхшээлийг олж мэдэхийн тулд хоёр талт харилцаанд төвлөрсөн харилцаа холбооны зорилтот кампанит ажлаас эхлэх нь зөв болно.

Нөлөөлөлд өртсөн малчин Мөнхчулуунтай ярилцлага хийж байгаа нь

ДҮГНЭЛТ & ЗӨВЛӨМЖҮҮД

Уул уурхайн том компани, түүний нөлөөлөлд өртсөн малчид, орон нутгийн засаг захиргаа хоорондоо сайн санааны үүднээс хэлэлцэн тохирсон түүхэн Гэрээнүүдийг 18 сарын өмнө ГТЗ байгуулсан билээ. Хэрэгжилт ч ихээхэн ахицтай, ГТЗ-ийн хүчин чармайлтын ачаар нутгийн иргэд үр өгөөж хүртэж эхэлж байгаа зэрэг нь тэд хийсэн ажлаараа бахархах шалтгаан мөнөөсөө мөн. Гэлээ ч ГТЗ-ийн өмнө хийх ажил их байна. Үүрэг амлалтын зөвхөн 29% нь бүрэн хэрэгжсэн, тэдгээрийн бараг тал нь 2017 оны 5 сард талууд Гэрээнд гарын үсэг зурахаас өмнө хийж гүйцэтгэсэн ажлууд юм. Түүнчлэн үүрэг амлалтын 53% нь ГТЗ-ийн тогтоосон гүйцэтгэлийн хугацаанаас хоцорч явна.

Тулгамдаж буй асуудал их, харилцан уялдаатай хамтын ажиллагаагүйгээр хэрэгжилтийг сайжруулахад бэрх. Гадагшаа харилцаа холбоо муу, Гэрээнүүдийн анхдагч зориулалттай тохирохгүй төслүүд гэх мэтийг хянаж залруулахгүй бол ГТЗ-ийн хүчин чармайлт талаар болж, 2017 оны 5 сард Гэрээнүүдэд гарын үсэг зурах үед талуудын тавьсан зорилтыг хангаж чадахгүй үр дагаварт хүрч мэднэ.

Талууд тохиролцон, Гэрээ байгуулахад ОУСК-ийн ЭЗХНЗОГ-аас үзүүлсэн туслалцаа дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд хэрэгжилтийн явцад ч үзүүлж буй дэмжлэг нь мөн адил ач холбогдолтой билээ. ОТ-н гол

санхүүжүүлэгч байгууллагын хариуцлагын механизм болох ЭЗХНЗОГ-ын мониторинг ГТЗ-д хэрэгжилтийг хангах урам зориг өгч, төвөгтэй асуудлыг гарсан дор нь шийдвэрлэхэд тэд байнга туслалцаа үзүүлж ирсэн. Гэлээ ч ГТЗ-ийн саяханы санал хураалтаар ЭЗХНЗОГ-ын мониторингийн үе шатыг дуусгахаар болсон. ГТЗ мониторинг, хяналтын бие даасан үйл явцыг даруй шинээр эхлүүлэхгүй бол талууд Гэрээнүүдийн зорилтыг ханган биелүүлэх үүрэг хариуцлагаа хэрхэн хүлээж, бүх хүч бололцоогоо яаж дайчлах нь тодорхойгүй байна.

Хэрэгжилтийг бодитой, бүрэн гүйцэт хангахын тулд ГТЗ дараах зүйлсийг хийж гүйцэтгэх шаардлагатай, үүнд:

- Гэрээнүүдийн үүрэг амлалт тус бүрээр хэрэгжилтийн хугацааг бодитоор шинэчлэн тогтоох. Тогтоосон хугацааг олон нийтэд ил тод мэдээлэн, улирал тутам сүүлийн үеийн байдлаар мэдээлэл өгч байх;
- Фейсбук, багийн хурал дээр бичгээр болон амаар мэдээлэл өгөх, айл өрхүүдээр орох гэх мэт тухайн бүлэгт тохиромжтой төрөл бүрийн хэлбэр, хэрэгслийг ашиглан малчидтай эргэх холбоотой харилцах боломж бүхий мэдээллийг олон нийтэд түгээх тогтолцоо бий болгох. Сүүлийн үеийн мэдээлэл өгөхдөө тогтмол давтамжтайгаар үүрэг амлалт тус бүрийн явцын талаар дэлгэрэнгүй тайлбарлах;
- Хэрэв тухайн үүрэг амлалт тодорхой тооны хүмүүст үр өгөөжөө өгөх зориулалттай бол тэрхүү өгөөжийг хүртэх хүмүүсийг сонгох шударга, ил тод, үндэслэлтэй үйл явцыг ойлгомжтой мэдээлэх;
- Хэрэв ямар нэг үүрэг амлалтыг үнэхээр хэрэгжүүлэх боломжгүй бол нутгийн малчдын хувьд түүнтэй адил ач холбогдолтой байх шинэ үүрэг амлалтаар орлуулан солих. Аливаа үүрэг амлалтыг орлуулан сольсон эсвэл өөрчлөлт хийсэн тохиолдолд малчдад цаг тухайд нь, ойлгомжтой мэдээлэх;
- Тодорхой үүрэг амлалтыг хэрэгжүүлэхдээ дэвшилтэт аргыг өргөнөөр ашиглах, бүх үүрэг амлалтын тухайд ийм байдлаар хандах. Хэрэгжилт малчдын суурь хэрэгцээг хангах явдлыг баталгаажуулахын тулд настай малчид, эмзэг өрхүүдэд зориулсан үүрэг амлалтуудыг тодорхой тайлбарлаж өгөх зэрэг үүнд орно;
- ОТ, Ханбогд сумын засаг захиргаа төслийн цаг хугацаа, хамрах хүрээ, ГТЗ хяналт тавих боломж гэх мэт үүрэг амлалтын нөхцөлийг хангуулж чадахаар бол, нөгөө талаар тухайн зохицуулалт Аймгийн хэмжээний хөгжлийн зорилтуудтай зөрчилдөхгүй тохиолдолд л Говийн Оюу Сангаас хэрэгжилтийн санхүүжилт, дэмжлэг авахаар хандах;
- Мэргэжилтний туслалцаа шаардлагатай ажлуудыг тодорхойлон, туслалцаа үзүүлэхээр гэрээ хийсэн байгууллага, хүмүүстэй ХОСБ байгуулах эсвэл адилтгах баримт бичигт гарын үсэг зурах. ХОСБ-т төслийг хэрэгжүүлэх цаг хугацаа, хамрах хүрээ, Гэрээний зорилтуудыг хангуулах ГТЗ-ийн үүрэг, гэрээт гүйцэтгэгч төслийг Гэрээний дагуу хийж гүйцэтгээгүй тохиолдолд ямар хариуцлага тооцох зэргийг тодорхой тусгаж өгөх хэрэгтэй;
- ГТЗ-ийн ажлын талаарх орон нутгийн засаг захиргааныхны ойлголтыг сайжруулах, идэвх зүтгэл гаргахгүй байгаа гишүүдийг сольж байх, ГТЗ-ийн дэргэд Малчдын Зөвлөлдөх Хороо байгуулах гэх мэтээр ГТЗ-ийн төлөөлөгчдийн чадавх, үүрэг хариуцлагыг тогтмол дээшлүүлэх; түүнчлэн
- ЭЗХНЗОГ-ын үүргийг орлон гүйцэтгэх мониторинг, хяналтын найдвартай үйл явцыг бий болгох. Тэрхүү үйл ажиллагааны явцад хөтөлбөрт үнэлгээ хийхдээ мэргэжлийн шинжээчдийг оролцуулах ба хэрэгжилтийн ахицыг мөшгин, бүртгэх мониторингийн үүрэг мөн түүнчлэн гэрээг хэрэгжүүлснээр малчдад хүргэхээр зорьсон үр дүнд хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж, шаардлагатай өөрчлөлтүүдийн талаар зөвлөмж өгөх хяналтын үүрэг аль алиныг хавсруулан хийх ёстой.

accountability counsel

244 Kearny Street, Floor 6
San Francisco, CA 94108
www.accountabilitycounsel.org
@AccountCounsel

Гэрээний явцын тухай
мэдээллийг GTZyavts.com
сайтаас үзнэ үү.